

ЭГЭЭББ судалгааны төсөл, Монгол улс

Борнуур сумын тайлан

2017 оны 6-р сар

Е.Далей, К.Ланз, Я.Нарангэрэл, Н.Лхамдулам, З.Дрисколл, Б.Сувд,
Б.Мөнхтүвшин, Ж.Грахам, Р.Эрдэнэбат



ЭГЭЭББ судалгааны төсөл, Монгол улс – Борнуур сумын тайлан, 2017 оны 6-р сар,
цахим хувилбарыг дараах хаягаар авна уу: www.mokoro.co.uk/wolts.
Текст © ЭГЭЭББ төслийн баг. Бүх фото зураг © ЭГЭЭББ төслийн баг.

ЭГЭЭББ судалгааны төсөл, Монгол улс

Борнуур сумын тайлан

2017 оны 6 - р сар

Танилцуулга – ЭГЭЭББ судалгааны төслийн арга зүй	1
Байршил, хүн ам	2
Борнуур сумын дөрвөн баг	3
Хүн ам, эдийн засгийн өөрчлөлтийн сүүлийн үеийн түүх	3
Социализмаас шилжилт	4
Амьжиргаа ба жендерийн харилцаа	5
Гэрлэлт, гэр бүлийн нөхцөл байдал	5
Боловсрол	7
Хөрөнгө чинээ, ядуурал	8
Орон сууц	8
Өмч хөрөнгө	9
Цахилгаан, ус, ариун цэврийн хангамж	9
Тээврийн хэрэгсэл	10
Үндсэн амьжиргаа	11
Мал аж ахуй	14
Газар тариалан	16
Жендерийн харилцаа	17
Уул уурхайн компаниуд болон бичил уурхай	18
Уул уурхайн нөлөөлөл	19
Гар аргаар алт олборлох үйл ажиллагааг хууль ёсны болгох нь	21
Бүцаад хууль бүс үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь	21
Газрын хомсдол, газрын төвлөрөл, байгаль орчны талхагдал	22
Бэлчээрийн талхагдал, усны хомсдол	23
Ой	24
Газар олгох үйл явц	25
Орон сууцны газар	26
Хүнсний ногоо, тэжээлийн тариалангийн газар	29
Газрын маргаан	30
Бэлчээрийн газрын менежмент	31
Өвөлжөө, зуншилгаа, бэлчээрийн газрын хүртээмж	31
Хадлангийн газар	33
Өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхүүдэд тулгардаг асуудлууд	34
Дүгнэлт	35

Товчлол

АМХЭГ	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
ЗБУ	Зорилтот бүлгийн уулзалт
ОН	Ойн нөхөрлөл
ХХЯ	Хувь хүний ярилцлага
ХТБХ	Хүн Төвтэй Байгаль Хамгаалал
ШХА	Швейцарын Хөгжлийн Агентлаг
ЭГЭЭББ	Эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн эрхийн баталгаат байдал

Танилцуулга – ЭГЭЭББ судалгааны төслийн арга зүй

Мокоро байгууллагын практик, үйл ажиллагаанд суурилсан урт хугацааны стратеги баримтлан гүйцэтгэж буй Эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн эрхийн баталгаат байдал (ЭГЭЭББ) судалгааны төсөл нь “Монгол болон Танзани улсад эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн аюулгүй байдалд учруулах аюулыг судлах” судалгааны арга зүйг түршиж байгаа юм. Монгол улс дахь Хүн Төвтэй Байгаль Хамгаалал ТББ-тай хамтран уул уурхайн хөрөнгө оруулалтын нөлөөлөлд өртсөн бэлчээрийн газар нутаг дахь эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн баталгаат байдал ямар байгааг танадан судалж, эмэгтэйчүүдийн болон нийгмийн эмзэг бүлгийн газрын эрхэд учруулах гол аюулуудыг тогтоохын тулд хамтын оролцооны болон тоон судалгааны аргын аль альныг нь ашиглан судалгаа хийж байна. ЭГЭЭББ төслийн зорилго нь газар эдэлбэрийн засаглал дахь жендерийн эрх тэгш байдлыг сайжруулах, эмзэг бүлгийнхний газрын эрхийн баталгаат байдалд учирж буй нутгийн иргэдийн дотооддоо байгаа аюулаас хамгаалан дэмжих боломжийг судлах юм. Мөн нутгийн иргэдэд тэдний газар болон байгалийн нөөцөд учруулах гадны аюул заналаас сэргийлэхэд туслах зорилготой билээ. (ЭГЭЭББ төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудаснаас үзээрэй: <http://mokoro.co.uk/project/wolts>)

Энэхүү сумын тайланд 2016 оны 4-р сараас 11-р сарын хооронд бидний хийсэн анхны танилцах аялал, суурь судалгаа болон хамтын оролцооны судалгааны үр дүнг харуулж байна. Бид 2016 оны 8-р сард суурь судалгаагаа Борнуур сумын бүх багын нийт өрхийн 10% -ыг хамруулан явуулсан. Нийт 142 өрх хамрагдсан бөгөөд 111 өрх нь санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон бөгөөд нэмж 31 өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхийг зориудаар сонгосон. Өөрөөр хэлбэл судалгааны нийт түүврийн 78 % нь санамсаргүй түүврийн аргаар сонгосон (82 эрэгтэй болон 29 өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхүүд), 22% нь зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд байв. Ингэж өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхүүдийг судалгаанд илүү олноор хамруулж эмзэг бүлгийн жендерийн асуудлуудыг олж тогтоох зорилготой байв. Өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхөөс цуглуулсан нэмэлт 31 өрхийн мэдээллийг суурь судалгааны бүх ерөнхий дүн шинжилгээнд оруулалгүй харьцуулсан байдлаар дүн шинжилгээ хийв.

Бид 2016 оны 11-р сард хамтын оролцооны аргаар судалгаа хийж нийт 102 хүнийг хамруулсан 14 зорилтот бүлгийн үүлзалт (ЗБУ), хүнтэй 11 хувь хүний ярилцлага (ХХЯ) хийсэн байна. Суурь судалгааны шинжилгээний үр дүнд үндэслэн цаашид нарийвчлан судлах шаардлагатай байсан нийгмийн янз бүрийн бүлгийн төлөөллүүд болон хувь хүмүүстэй тусгайлсан үүлзалт, ярилцлага хийхийг зорьсон (жишээ нь, бэлэвсэн хүмүүс, уурхайчид, гэрлэсэн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд гэх мэт). ЗБУ-ын бүтцийг оролцооны аргуудыг ашиглаж боловсруулсан (байгалийн нөөцийн зураглал, нүүдлийн зураглал, улирлын хөдөлмөрийн ачаалал, оролцогч талуудын зураглал, дүн шинжилгээ). ХХЯ – н бүтцийг урьдчилан боловсруулж ярилцлага хийж буй хувь хүний нөхцөл байдалд тохируулан тэдний амь амьдрал, амьжиргааны талаар, тэдний хүүхэд байхаас нь эхлээд янз бүрийн байгалийн нөөцийг олж хүртэх хэлбэр, жендерийн харилцааны талаар аль альных нь тухай мэдэж авах зорилготой асуултууд байв. Мөн бүх ЗБУ болон ХХЯ-д чөлөөт ярилцлагын цаг гаргаж байсан.

Мөн бид судалгааны хүрээнд орон нутгийн засаг захиргааны мэргэжилтнүүд, Борнуур суманд ажиллаж буй байгууллагууд, компаниудын төлөөллүүдтэй ярилцлага хийсэн.

Бидний судалгааны ажилд оролцож, элгэмсэг хандсан Борнуурын бүх ард иргэддээ талархаж байгаагаа нуух юун. Ялангуяа бидний ярилцлага, хэлэлцүүлэгт оролцож жендер, газар, бэлчээр, уул уурхайн асуудлуудыг танин мэдэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хүмүүст талархлаа илэрхийлье.

ЭГЭЭББ төслийн багын гишүүд- Е.Далей, К.Ланз, Я. Нарангэрэл, Н.Лхамдулам, З.Дрисколл, Б.Сувд, Б.Мөнхтүвшин, Ж.Грахам, Ж.Эрдэнэбат. Энэхүү тайлан нь бидний хийж гүйцэтгэсэн хамтын бүтээл юм.

Байршил, хүн ам

Борнуур сум Улаанбаатар хотоос хойш 115 км-ийн зайд Төв аймагт оршдог. Нийт газрын хэмжээ нь 114, 687 га бөгөөд үүнээс ойролцоогоор 36,000 га нь ой, 68,000 га нь бэлчээр, 8,100 га нь тариалангийн талбай юм. 2015 оны 3-р сарын 3-ны байдлаар сумын хэмжээнд 18 уул уурхайн лиценз олгосон бөгөөд үүнээс 6 нь олборлолт, 12 нь хайгуулын лиценз юм. Борнуур сумын гол ашигт малтмалын нөөц алт юм. Борнуур сум нийт 4 багтай, Өгөөмөр, Мандал багууд сумын төвийнх харин Бичигт, Нарт нь хөдөөний багууд бөгөөд малчдын ихэнх нь амьдардаг.

2016 оны 8-р сарын 4 –ны байдлаар нийт 5,059 хүн амтай, 1,404 өрхтэй байв. Багуудын өрхийн тоон 1-р хүснэгтэд харуулав. Сумын хүн амын нягтрал 1 га –д 0.04 хүн ноогдож байна. Газар зүйн хувьд 4 багын хэмжээ харилцан адилгүй, багын тухай мэдээлэл дутмагаас баг бүрийн хүн амын нягтралыг тооцоолох боломжгүй байсан.

Хүснэгт 1. Борнуур сум, багуудын өрхийн тоо

Багын нэр	Өрхийн тоо
Нарт	293
Өгөөмөр	438
Бичигт	359
Мандал	314
Борнуур сумын нийт тоо	1,404

Эх сурвалж: 2016 оны 8-р сарын 4. Борнуур сумын захиргаанаас гаргасан албан ёсны мэдээлэл.

Ярилцлага авсан өрхүүдээс нэг хот айлд ноогдох өрхийн тоо ихэвчлэн нэг байсан ч (111 санамсаргүй түүврээр сонгогдсон өрхийн 70 нь) Нарт багын нэг өрхийн хувьд хот айлдаа 12 өрхтэй, бас өөр нэгэн өрхийн хувьд 13 өрхтэй нэг хот айлд байдаг гэсэн байна.

Суурь судалгаанд нийт 60 өрх толгойлсон эмэгтэйчүүд хамрагдсан ба үүнээс 29 нь 111 санамсаргүй түүвэрт байсан ба санамсаргүй түүврийн 26% юм . Сумын нийт дүнд шилжүүлэн тооцвол судалгаа явагдах үед сумын хэмжээнд нийт 365 өрх толгойлсон эмэгтэй байсан гэсэн тооцоо гарч байна.

Санамсаргүй түүвэрт байх нэг өрхийн дундаж гишүүний тоо 3.96 хүн гэж гарсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй нэг өрхийн дундаж гишүүний тоо 3.93 байна. Тэргүүн нь эрэгтэй 82 өрхийн дундаж гишүүний тоо 4.28 байна.

Санамсаргүй түүврийн өрхөд нийт 440 (221 эмэгтэй, 219 эрэгтэй) хүн амьдардаг байсан ба 2-р хүснэгтэд насны бүтцийг харуулав.

Хүснэгт 2. Борнуур сумын санамсаргүй түүврийн өрхөд амьдарч буй хүмүүсийн насны бүтэц

Нас (жилээр)	Хүмүүсийн тоо	Насны бүлэгт байгаа хүмүүсийн эзлэх хувь
5 ба түүнээс доош	46	10%
6 to 12	59	13%
13 to 18	60	14%
19-24	39	9%
25-34	62	14%
35-44	59	13%
45-54	61	14%
55-64	30	7%
65-74	15	3%
75 ба түүнээс дээш	9	2%
Нийт	440	100%

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. N = 440.

2-р хүснэгтэд байгаа мэдээлэлд үндэслэн нийт хүн амд шилжүүлэн тооцвол Борнуурын 37% нь хүүхэд (18 ба түүнээс доош настай), 5% нь ахмадууд (65 ба түүнээс дээш настай), 57% нь хөдөлмөрийн насны насанд хүрэгсэд (19 аас 64 настай) байна. Борнуурын хүн амын залуулаг байдал буюу хүүхдийн эзлэх хувь нь насанд хүрсэн залуучуудтай (19-24 ба 25-34) харьцуулж үзвэл харин бага болж байна. Бидний санамсаргүй түүврийн өрхийн хөдөлмөрийн насны хүмүүсийн 40% -г насанд хүрсэн залуучууд эзэлж байгаа бөгөөд түүврийн нийт өрхөд амьдарч байгаа хүмүүсийн 60% нь 35 ба түүнээс доош насныхан байв.

Борнуурын хүн амын ихэнх нь халх үндэстэн буюу санамсаргүй түүврийн өрхийн тэргүүлэгчдийн 89 % (99) нь халх хүмүүс байна. Мөн ихэнх нь буюу 68% (75) нь буддын шашин шүтдэг байна. Санамсаргүй түүврийн өрхийн тэргүүлэгчдийн хорин зургаа хувь нь (29) нь ямар нэгэн шашин шүтлэггүй гэж хариулсан байна. Үлдсэн нь бөөгийн юмуу христийн шашинтай хэмээн өөрсдийгөө тодорхойлсон байна. Мөн суманд Баяд, Дөрвөд, Хотгойд, Хотон, Урианхай хүмүүс амьдардаг нь харагдсан.

Борнуур сумын дөрвөн баг

Борнуур сумын төв Өгөөмөр багт байдаг бөгөөд төрийн байгууллагууд, эмнэлэг, дунд сургууль, цэцэрлэг байдаг. Өгөөмөр багын өрхүүд эзэмших юмуу өмчлөх эрхтэй хашаа байшин, гэрт амьдардаг. Сургуулийн насны хүүхэдтэй малчин өрхүүд хичээлийн жилд Өгөөмөрт амьдарч, зун цагт Нарт баг руу зуншдаг. Борнуур сумын хөдөөний баг нь Нарт бөгөөд ихэнх өрх нь уламжлалт малчин өрх байдаг. Борнуурын баруун хэсгийн орон нутгийн тусгай хамгаалалттай ой Нарт багт байдаг бөгөөд газрын ихэнх нь бэлчээр, хадлангийн талбай байдаг. Мөн гол жүүлчны баазууд Нартад байдаг. Төв аймгийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар буюу хамгаалалтад авсан ой Борнуур сумын баруун хэсэгт байдаг.

Бичигт багын ихэнх газар нь бэлчээрийн газар байсан хэдий ч одоогийн байдлаар ихэнх нь эзэмших эрхтэй өвөлжөө, хадлангийн юмуу тариалангийн талбай байна. Бичигт багын ихэнх малчид Нарт баг руу зуншлагад гардаг ба зарим нь хагас эрчимжсэн эсхүл эрчимжсэн мал аж ахуй, тариалан эрхлэгчид байна. Бичигт багт мөн алтны ордууд байдаг. Борнуур багт ганц ажиллаж байсан хоёр уурхайн аль аль нь ойн бүсэд байдаг. Бичигт багын ихэнх хэсэг нь ойт бүс хийгээд бэлчээрт ашиглагддаг, Борнуур суманд бүртгэлтэй 10 ойн нөхөрлөлийн (ОН) гурвынх нь эзэмшилд олгосон байдаг. Ойн нөхөрлөлүүд ойн зарим хэсгийг хашаалж малчдыг оруулахааргүй болгосон байдаг. Мөн Нарт багын 6 ойн нөхөрлөлд ойн газар олгосон байдаг ба Мандал багт нэг ойн нөхөрлөл байдаг.

Мандал баг нь хамгийн сүүлд байгуулагдсан бөгөөд ихэвчлэн сумын төвд (Өгөөмөр багт) ажилладаг төрийн албан хаагчид, багш нар амьдардаг. Сумын төв нь 1980 аад онд байгуулагдсан ч 1990 оныг хүртэл Мандал багт бараг хүн амьдарч байгаагүй. Мандал багыг хойд, урд хувааж байгаа голтой, гүүр барьсан байдаг. Хойд хэсгээрээ хоёр газар гэр хороололтой. Гэр хорооллын айлууд бүрэн суурьшиж хашаа байшингаа өмчлөх эрхтэй авсан. Мандал багын өрхүүд ихэвчлэн хагас эрчимжсэн мал аж ахуйн эрхэлж малаа хашаандаа тэжээж, зун цагт багын урд руу бэлчээрт гаргадаг.

2016 оны бидний ажлын үеэр төв зам дагуу шинэ суурьшлын бүс төлөвлөгдсөн байсан ба дэд бүтэц байхгүй учир хүмүүс тийш нүүх сонирхолгүй байсан.

Хүн ам, эдийн засгийн өөрчлөлтийн сүүлийн үеийн түүх

Анх 1923 онд одоогийн Борнуур сум байгуулагдсан (хуучнаар Түшээт хан аймаг) ба нэрээ хэд хэд сольсны эцэст 1959 онд одоогийн Борнуур нэртэй болсон. Социализмын үед Борнуур суманд (Өгөөмөр багт) сүү, төмсний нэгдлийн ферм байсан ба сум үндэсний хэмжээнд төмс нийлүүлэлтээрээ алдартай байсан. Сумын захиргааны мэдээлснээр сум цаг агаар, хөрс сайтай учир 1955 оноос хойш сүү, ногооны үйлдвэрлэлийг төрөөс дэмжиж байсан ба 1962 оноос

Монгол улсын засгийн газраас Улаанбаатар хотын төмс, сүүний хэрэгцээг хангах үүднээс орчин үеийн үнээний фермийн аж ахуйг онцгойлон хөгжүүлэхийг зорьж услалтын систем, хөдөө аж ахуйн технологийн тал дээр дэмжлэг үзүүлсэн. Борнуур сум социализмын үед сүү, төмсний үйлдвэрлэлийн чанараараа хэд хэдэн гавьяа шагнал хүртэж байсан. ЗБУ болон ХХЯ-д оролцсон хүмүүсийн яриагаар услалтын системтэй болсноор хүнсний ногооны үйлдвэрлэл сайжирч, мал аж ахуйн фермд Германы тоног төхөөрөмж нэвтрүүлсэн. Олон хүмүүс 400 болон 800 үнээний фермийн тухай, эдгээр фермүүд нь бүрэн механикжсан, тэжээлийн үйлдвэртэй байсан тухай ярьсан. Зүүн Германы алтны уурхай ойролцоогоор 1979 - 1990 оны хооронд Борнуур сумын Бичигт багын нутагт ажиллаж байсан ч социализмын үед гар аргаар уурхай эрхэлж байсан хүн үгүй гэж санагдсан.

Тэр үед бусад сумын олон малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүд Борнуур суманд төрийн томилгоогоор очиж, төрийн мэдлийн малыг хариуцан ажилладаг байсан байна. Зарим гадны хүмүүс Борнуур суманд малчин болохоор өргөдөл гаргадаг байсан. Бүх газар төрийн мэдлийнх байв. Тэр үед хашаа барьдаггүй байсан ба мал аж ахуйн, тариалангийн бүтээгдэхүүний ихэнх хэсгийг төрийн байгууллагуудад тушаадаг байсан. Нэгдэл бүх зүйлийг зохицуулдаг байсан ба өрхүүд хэрэгцээний цөөн тооны малын мэдэлтэй байв. Бууц барих газрыг төрөөс зохицуулж, баталдаг байсан бөгөөд сумын засаг дарга нүүдэл суудлыг зохицуулж хэн хэзээ хаашаа нүүхийг мэддэг, нэгдлээс унаа тэргээр хангадаг байв. Малчид нүүсний дараа тухайн газар дээр тариалалт хийгдэж байсан учир тэдний хоорондын зөрчил бага байв.

Ихэнх ЗБУ болон ХХЯ-ын оролцогчид тэр үеийн талаар сэтгэл хөдлөм ярьж байсан ба хүн бүр шаргуу ажилладаг, ажилгүй хүн гэж байхгүй байсан тухай дурссан. Мөн тэдний зарим нь тэр үед байгаль их сайхан байсан, сумын бэлчээр сайн, олон гол горхи урсдаг байсан тухай ярьсан.

Социализмаас шилжилт

1990-ээд оны эхээр Монгол улс ардчилсан нийгэм рүү шилжиж, хувьчлал гэнэтийн явдал болсон. Төрийн өмчийн нэгдлийн сангийн аж ахуй, үнээний хоёр фермийг нэгдлийн ажилтнуудад хувьд нь тараан олгосон. Нэгдлийн мал маллаж байсан малчид маллаж байсан малаа, нэгдлийн трактор барьж байсан жолооч трактораа, тоног төхөөрөмжийг нягтлан бодогч, инженерүүдэд олгох мэтээр тараан хувьчилсан байна. Хүмүүс хамтаар эсхүл бие даан ажиллах эсэх нь дүр чөлөөтэй тавигдсан. Нэгэнт менежментгүй болсон учир социализмын үед хэвийн ажиллаж байсан тоног төхөөрөмж эвдэрч, дампуурал нүүрлэж, үйлдвэрлэл зогссон хэмээн манай ЗБУ, ХХЯ-д оролцсон оролцогчид дурсаж байлаа. Мөн энэ үед Улаанбаатар хотын чинээлэг иргэд Борнуур суманд газар авч дөнгөсөн бололтой.

Борнуур сумын энгийн иргэд өөрчлөлтөд хүчтэй өртсөн. Олон хүмүүс ажилгүй болж барааны үнэ нэмэгдсэнээр тэдэнд амьжиргааныхаа үндсэн хэрэгцээгээ хангахад хэцүү болов. 1990-ээд оны ядуурлын үед Борнуурын ажилгүй, цөөн малтай иргэд Улаанбаатар хот руу ажил хайхаар явсан бол Баянхонгорын Говийн бүс, баруун аймгуудийн иргэд уул уурхай, мал маллах, Улаанбаатар хотын мах, сүүний томоохон зах зээлтэй ойр байх, бэлчээрийн сайныг нь бодож Борнуурт ирцгээж байв.

Шинэ нөхцөл байдалд дасан зохицохын тулд Борнуурын сумандаа үлдсэн олон ажилгүй иргэд хуучин Зүүн Германы 1992 онд үлдээсэн уурхайд гар аргаар (хууль бүс) олборлолт хийж эхэлсэн. Ихэвчлэн эрчүүд хад чулуу дэлбэлэн цөмөлж, орд руу орох өндөр эрсдэлтэй ажлыг хийдэг байсан ч эмэгтэйчүүд бас тогоо барих, баяжмал угаах зэрэг ажлыг хийж зарим нь эрчүүдтэй хамт уурхай руу ордог байв.

Борнуур сумаас олдсон их алтны сургаар бусад газраас хүмүүс ирж азаа үзэх болов. ЗБУ, ХХЯ-ын оролцогчид тэр үед зодоон цохион, биеэ үнэлэлт, хүчирхийлэл газар авсан байсан ба сумынхан тэр аяараа нэрвэгдэж байсан тухай ярьсан. Тэд зарим хүмүүс уурхай цөмөрснөөс үүдэж амь насаа хүртэл алдаж байсан тухай санагалзав. Алтыг ууланд цианид, мөнгөн үс хэрэглэж угаадаг байснаас Борнуурын голуудыг бохирдуулсан. Энэхүү уул уурхайн үйл


ажиллагаа хүмүүсийн эрүүл мэндийг ихээр хохироож байсныг сүүлд олон уурхайчид уушигны өвчин тусах болсноор мэдсэн.

Гэсэн хэдий ч уул уурхайн үйл ажиллагаа явагдсанаар Борнуур сум хурдан хөгжиж сумын төвд хэд хэдэн том дэлгүүр нээгдсэн. Нэг талаараа сумын эдийн засаг сайжирсан гэж хэлж болох. Учир нь гар аргаар алт олборлогчид бусад сум руу явж ухахгүйгээр сумандаа үлдсэн. Сүүлийн жилүүдэд хотын чинээлэг иргэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх сонирхлоор Борнуур суманд ирэх болсон. Мөн тэд тэжээл тарих гэх мэт арилжааны таримал ургамлын тариалалт эсхүл аялал жуулчлал эрхлэхээр ирэх болсон. Зарим тохиолдолд Улаанбаатарын бохир агаараас зугатаж хүмүүс тэтгэвэрт гарахаараа ирдэг болсон.

Улаанбаатар хоттой ойр таатай байршил, төв засмал зам сумаар дайран өнгөрдөг, алтны олдоц сайтай, бэлчээр, тариалангийн нөхцөл сайтай гэсэн шалтгаануудын улмаас зах зээлд шилжсэнээс хойш Борнуурт нүүж ирэгсэд олширсон. Социализмын үед хүмүүс дур зоргоороо шилжин явах хориотой байсан бол сүүлийн жилүүдэд баруун аймгуудад болсон зуд гэх мэтээс шалтгаалан хүмүүс газар нутагтаа амьдрах нөхцөлгүй болсон тохиолдолд сайн дураараа Борнуурт ирэх нь ихсэв. Ингэснээр Борнуурын газрын хүрэлцээ муудаж, газартай холбоотой маргаан гарах нь ихсэв.

Социализмын үед бусад сумдаас шилжин ирэгсэд их байсныг 1-р зураглалд үзүүлсэн бөгөөд санамсаргүй түүврийн өрхийн тэргүүлэгчдийн талаас бага нь Борнуур суманд төрсөн байгаагаас харагдаж байна. Гэр бүлийн хүнээ дагаж, гэрлэж эсхүл төрийн томилгоо (социализмын үед багшлах, эмнэлэг, цэргийн анги гэх мэтэд ажиллах) авч Борнуурт нүүж ирсэн хүмүүс байлаа. Хөдөөний Нарт багын санамсаргүй түүврийн өрхийн тэргүүдийн 72 % (18) нь насанд хүрсэн үедээ Борнуур руу нүүж ирсэн байсан нь бусад багынхтай харьцуулахад хамгийн өндөр тоо болж байна. Харин эсрэгээрээ суурин баг болох Мандал, Өгөөмөр багын санамсаргүй түүврийн өрхийн тэргүүдийн 46% (7), 52% (14) нь Борнуурт төрсөн байна.

Зураглал 1. Борнуурт шилжин ирэгсдийн тухайн үеийн насны байдал



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. N = 111.


Амьжиргаа ба жендерийн харилцаа

Гэрлэлт, гэр бүлийн нөхцөл байдал

Бидний суурь судалгаанаас харахад Борнуурын ихэнх насанд хүрсэн иргэд хууль ёсоор гэрлэсэн байсан ч өрх толгойлсон эмэгтэйчүүд их байгаа нь харагдсан. Дээр дурьдсанчлан санамсаргүй түүврийн өрхийн 26 % (111 өрхийн 29 нь) нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байв. Харин 74% (82) нь өрх толгойлсон эрэгтэйтэй өрх байв. 2-р зураглалд Борнуур суманд бэлэвсэрсэн хүмүүс

олон байгааг харуулж байна. Манай суурь судалгаанд оролцсон нийт 60 өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 67% нь бэлэвсэн эмэгтэй байв. Нийт санамсаргүй түүврийн өрхийн арван найман хувь нь (111 өрхийн 20 нь) бэлэвсэн өрхийн тэргүүнтэй байсан нь бараг тавны нэг нь юм.

Зураглал 2. Борнуур сум, Тэргүүн нь эмэгтэй өрхийн гэрлэлтийн байдал (зүүн тал), Тэргүүн нь эрэгтэй өрхийн гэрлэлтийн байдал (баруун тал)



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Эмэгтэйчүүдийн зураглалд санамсаргүй түүврийн өрхүүд, зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийн мэдээллийг хамтатган харуулсан. Өрх толгойлсон эмэгтэй өрхүүдийн түүврийн хэмжээ N = 60. Өрхийн тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Нийт 60 өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн найман хувь нь ганц бие, гэрлэж байгаагүй, харин нийт 82 тэргүүн нь эрэгтэй өрхийн 5 % нь гэрлэж байгаагүй байна. Салалтын хэмжээ харьцангуй бага байсан бөгөөд энэ нь оролцооны судалгаагаар бас батлагдсан. Нийт 111 санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 4 (4%) –ийн өрхийн тэргүүн салсан байсан гэж бүртгэгдсэн. Судалгаанд хамрагдсан өрхүүдээс нэг өрх нь албан ёсоор гэрлэсэн эмэгтэй өрхийн тэргүүн байв. Ийм учир албан ёсоор гэрлэсэн нийт өрхийн 98% нь эрэгтэй өрхийн тэргүүнтэй байна (64 өөс 63 нь) гэж үзнэ. Санамсаргүй түүврийн өрхийн албан ёсоор гэрлээгүй ч хамтран амьдарч буй есөн өрхийн (зургаа эрэгтэй, гурван эмэгтэй) долоо нь сумын төвийн Өгөөмөр багт амьдардаг байсан бөгөөд энэ багт хамгийн олон хүн шашин шүтдэггүй гэсэн тоо гарсан. Түүнчлэн нийт 82 эрэгтэй тэргүүнтэй өрхийн 4% нь гэрлэсэн гэхдээ албан ёсны баталгаагүй гэж бүртгэгдсэн байна. Хөдөөний малчид олонтой Нарт багт салсан, тусдаа амьдардаг, гэрлэж байгаагүй ганц бие эсхүл хамтран амьдрагчтай гэсэн хүмүүс байгаагүй.

Бидний суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхүүдийн арван дөрвөн хувь нь (15) доор хаяж ганц хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнтэй хэмээн тэмдэглэгдсэн. Нийт тэргүүн нь эрэгтэйтэй өрхийн есөн хувь нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн гишүүнтэй бөгөөд энэ тоо өрх толгойлсон эмэгтэй өрхүүдийн хувьд 27 % байна.

Судалгаа явуулж байх үед санамсаргүй түүврийн өрхийн 15 % нь (111-ын 17) өрхийн гишүүн бус ямар нэг хүн тухайн өрхөд амьдарч байгаа гэж тайлагнасан нь ач, зээ нар нь зуныхаа амралтаараа өвөө, эмээгийнхээ байгаа хүмүүс байсан. Нөгөө талаар, санамсаргүй түүврийн нийт 440 өрхийн гишүүдээс зөвхөн 85% (372 хүн) нь ихэвчлэн гэртээ амьдардаг гэж мэдээлсэн байна. Дөчин есөн хүн (11%) нь жилийн түрш өөр газар түр амьдардаг, харин 12 хүн (3%) дунд юуу үрт хугацаагаар өөр газар амьдардаг гэж мэдэгдсэн байна.

37 өрхийн 61 хүн эдгээр гэртээ амьдардаггүй (санамсаргүй түүврийн 33%). Эдгээр хүмүүс нь ихэвчлэн сургуулийн сурагчид, оюутнууд, мөн сум юуу аймгийн төвд хүүхдүүдээ сургуульд сурахад нь хардаг эцэг эхчүүд - ихэвчлэн эхчүүд байв. Бусад нь ажлын шаардлагаар өөр газар амьдардаг гэсэн бөгөөд өөр газар амьдардаг өрхийн тэргүүн байгаагүй.


Түүнчлэн санамсаргүй түүврийн өрх толгойлсон эмэгтэй, долоон гишүүнтэй нэг өрх улирлын чанартай өөр газар амьдардаг гэж мэдээлсэн нь малаа дагаж нүүх нь ховор байгааг харуулж байна. Зориудаар сонгож судалсан бүлгийн өрх толгойлсон эмэгтэй нэг өрх улирлаас шалтгаалж малаа дагаж нүүдэг хэмээн бүртгэгдсэн. Бидний суурь судалгаа зун цагт болсон бөгөөд зарим өрх малаа дагаж нүүсэн учир судалгаанд хамрагдаагүй байж болох талтай ч ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс уламжлалт нүүдэл суудал эрс багассан бөгөөд Борнуурын өрхүүдийн хувьд жирийн биш зүйл болсон хэмээсэн.

Социализмын үед (тэрнээс ч өмнө) малчид гэр бүлээрээ дөрвөн улирлын түрш нүүдэл хийдэг байсан. Өнөө үед Борнуурын малчдын гол нүүдэл нь суман дотроо өвөлжөө болон зуншилгааны хооронд болсон байна. Зарим хүмүүс хагас эрчимжсэн, эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг болсон бөгөөд олон хүмүүс өөрсдөө малтайгаа нүүхээ больж хамаатан садандаа өгч бэлчээрт гаргадаг болсон байна. Энэ тухай дараагийн сэдвүүдэд үзнэ.

Боловсрол

3-р зураглалд суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 6% (7) нь дунд сургуулиас дээш боловсрол эзэмшсэн дор хаяж ганц насанд хүрсэн эмэгтэй гишүүн байхгүй байсан. Харин тэдний 50% (56) нь дундаас дээш боловсрол (тусгай мэргэжлийн сургууль юмүү их сургууль) эзэмшсэн дор хаяж ганц насанд хүрсэн эмэгтэй гишүүнтэй байсан. Нөгөө талаар, тэдний 13% (14) нь дунд сургуулиас дээш боловсрол эзэмшсэн дор хаяж ганц насанд хүрсэн эрэгтэй гишүүн байхгүй байсан ба 35% (39) нь дундаас дээш боловсрол эзэмшсэн дор хаяж ганц насанд хүрсэн эрэгтэй гишүүнтэй байсан.

Зураглал 3. Борнуурын өрхүүдийн насанд хүрсэн эмэгтэйчүүд (зүүн), эрэгтэйчүүдийн (баруун) хамгийн өндөр боловсролын түвшин



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Түврийн тоо N = 111. N/A = тухайн өрхөд тийм хүйстэй насанд хүрсэн хүн байхгүй.

Ерөнхийдөө Борнуурын хөдөөний багт боловсролын түвшин бага насанд хүрсэн хүмүүс илүү байсан бөгөөд сумын төвийн багт боловсролын түвшин дээгүүр хүмүүс их байсан. 3-р зураглалд санамсаргүй түүврийн өрхийн насанд хүрсэн эмэгтэйчүүдийн олж авсан хамгийн дээд боловсролын зэргийн эхний гуравт орж байгааг нэрлэвэл “ахлах сургууль төгссөн, 12-р анги төгссөн” -26%, “тусгай мэргэжлийн сургууль төгссөн”- 23%, “их сургууль төгссөн”- 19% байв. Өрхийн насанд хүрсэн эрэгтэйчүүдийн хувьд боловсролын зэргийн эхний гуравт орж байгааг нэрлэвэл “ахлах сургууль 12-р анги төгссөн” -22%, “дунд сургууль 9-р анги төгссөн” - 16%, “их сургууль төгссөн”- 15% байв.

Нэгтгэж үзвэл манай судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 42% нь “тусгай мэргэжлийн сургууль төгссөн” эсхүл их сургууль төгссөн ядаж ганц насанд хүрсэн эмэгтэй гишүүнтэй байсан, мөн 29% нь ийм түвшний боловсролтой насанд хүрсэн эрэгтэй гишүүнтэй байсан байна. Энэ нь үндэсний хэмжээний мэдээлэлтэй ижил байгаа бөгөөд боловсролын хувьд жендерийн ялгаа байгааг тодорхой харуулж байна.


Хөрөнгө чинээ, ядуурал

Орон сууц

Санамсаргүй түүврийн өрхийн гучин дөрвөн хувь (38) нь гэртэй, 33% (37) нь байшинтай, 30% (33) нь аль алинтай нь байсан. Гурван өрх орон гэргүй байсан ба бусдын гэрт амьдарч байв. Гэртэй айлуудын хувьд дунджаар 1.2 гэртэй байсан ба Өгөөмрийн нэг айл дөрвөн гэртэй байв. Гэртэй айлууд ихэвчлэн 61% (71 өрхийн 43 нь) нь таван ханатай үндсэн гэртэй байсан. Нарт багын нэгэн чинээлэг өрх найман ханатай гэртэй байв.


4 ба 5 -р зураглалд орон сууцны хийц, материалын төрлийг харуулсан, судалгаанд оролцсон өрх бүрийн үндсэн сууцны дээврийн материал, ханын материалыг дээрээс нь (жишээ нь, хамгийн үнэтэйгээс нь) үзүүлэв.

Зураглал 4. Борнуур сум, Өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, эрэгтэй тэргүүнтэй өрхийн орон сууцны ханын материал



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн сурууь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Зураглал 5. Борнуур сум, Өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, эрэгтэй тэргүүнтэй өрхийн сууцны дээврийн материал



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн сурууь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.


Гэрийн материал эсгий, мод байдаг бол Борнуурын хувьд модон сууц голлож байв. Дээрх хоёр зураглалд үзүүлснээр өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд болон тэргүүн нь эрэгтэй өрхүүдийн

хувьд дээрээсээ адилхан “мод” ба “мод болон эсгий” гэсэн орон сууцны материал зонхилж байв. Нийтдээ санамсаргүй түүврийн 50% (56) нь “модон”, 34% (38) нь “мод болон эсгий” барилгын материалаар орон сууцныхаа байшин эсхүл гэрийхээ ханыг хийсэн гэв. Үүнд тэдэнд байгаа орон сууцны хамгийн өндөр үнэтэйг нь хэлж байгаа юм. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийн хувьд эрэгтэй тэргүүнтэй өрхүүдтэй харьцуулбал арай илүү “шатаасан тоосго”, “цементэн блок” оор хийсэн орон сууцны ханатай хэмээн мэдэгдсэн байна. Харин эсрэгээрээ, “мод” болон “мод болон эсгий” дээврийн материал нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдтэй харьцуулахад тэргүүн нь эрэгтэй өрхүүдэд харьцангуй илүү байсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийн орон сууцны дээврийн материал нь ихэвчлэн “төмөр”, “плита”, “хар цаас” байсан. Энэ нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд гэр гэхээсээ илүүтэй байшинд амьдарч байгааг харуулж байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн оролцоо бага байдаг тухай бид дараагийн сэдэвт тайлбарлана.

Өмч хөрөнгө

Борнуурын судалгаанд оролцсон ихэнх өрхүүд телевиз, хөргөгч, угаалгын машинтай байсан ба бүгд 100% гар утастай байсан. Энэ нь малчдад тустай, тэд цаг агаарын мэдээ хүлээн авч бэлтгэлтэй байх боломжтой. Гэхдээ мөнгөн аяганаас бусдаар өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, тэргүүн нь эрэгтэй өрхүүдийн хувьд ялгаа бага байсан. 6-р зураглалд өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийг бодвол тэргүүн нь эрэгтэй өрхүүдэд илүү олон мөнгөн аяга байгааг харуулж байна. Ихэвчлэн малчин өрхүүд хөрөнгөө хадгалах уламжлалын дагуу мөнгөн аягатай байдгаас харахад тэргүүн нь эрэгтэй өрхтэй харьцуулахад өрх толгойлсон эмэгтэйтэй өрх мал маллах нь бага буюу/эсхүл өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхүүд харьцангуй амьжиргаа муутай (ядуу) гэсэн санаа гарч байна.

Зураглал 6. Борнуур сум, Өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, тэргүүн нь эрэгтэй өрхүүдийн өмч хөрөнгө



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суруу судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Цахилгаан, ус, ариун цэврийн хангамж

Санамсаргүй түүврийн өрхийн ерэн есөн хувь (111) нь цахилгаанаар хангагдсан байсан. Тэргүүн нь эрэгтэй нэг өрх цахилгаанаар хангагдаж чадаагүй байсан. Ихэнх өрхүүд төвийн цахилгаантай холбогдсон. Өгөөмөр багын санамсаргүй түүврийн өрхийн 97% (32), Мандал багын өрхийн 96% (26), Бичигт багын өрхийн 81% (22) байсан ба үлдсэн нь ихэнх нь нарны тольтой байв. Нарт багын өрхийн зөвхөн 56 % (14) төвийн цахилгаантай холбогдсон ч 40% (10) нь зөөврийн нарны тольтой байсан.

Усан хангамжийн хувьд эрэгтэй болон эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхүүдийн хувьд ялгаа бараг байхгүй. Борнуурт жилийн түрш нийт өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 49% (29) нь ойролцоох гүний худагаас (төлбөртэй) ундны усаа авдаг. Зуны улиралд эрэгтэй тэргүүнтэй өрхийн 49% (40) нь ийм усны эх үүсвэрийг ашигладаг ба хаврын улиралд энэ нь 50% (41),

өвлийн улирлалд 52 (43) болж өсдөг байна. Хоёр дахь түгээмэл усны эх үүсвэр нь ойролцоох гүний худаг (нийтийн эсхүл хувааж хэрэглэдэг) бөгөөд тэргүүн нь эрэгтэй өрхийн 17% (14), тэргүүн нь эмэгтэй өрхийн 25% (15) нь бүх улирлын турш хэрэглэдэг байна. Усан санг Өгөөмөр, Мандал, Нарт багын гурван тэргүүн нь эрэгтэй өрх зөвхөн хавар, зуны улиралд ашигладаг. Өрх толгойлсон эмэгтэйтэй дөрвөн өрх, тэргүүн нь эрэгтэй 11 өрх хашаандаа хувийн гүний болон гүхэн худагтай бөгөөд бүх улирлын турш ашигладаг. Санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 4% (4) нь голын ус өвөл хэрэглэдэг, 6% нь (7) хавар, 9% (10) нь зун ашигладаг. Ихэвчлэн Нарт багын эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүд илүү хэрэглэдэг.


Ариун цэврийн хангамжийн хувьд суурь судалгаанд оролцсон санамсаргүй түүврийн өрхүүдийн 78% нь гадаанаа татуургагүй гүнзгий нүхтэй жорлонтой гэсэн байна. Орон сууц дотроо жорлонтой байх нь ховор байсан бөгөөд зөвхөн өрх толгойлсон эмэгтэйтэй нэг өрхөд байсан. Нийт өрх толгойлсон эмэгтэйтэй 60 өрхийн зөвхөн 5% нь өрхийн тэргүүн нь эрэгтэй 82 өрхийн 4% нь ерөөсөө жорлонгүй байсан. Мандал багын бүх өрх жорлонтой байсан. Гэхдээ өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийг өрхийн тэргүүн нь эрэгтэй өрхүүдтэй харьцуулбал арай илүүтэйгээр нийтийн жорлон ашигладаг гэж харагдсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 8%, тэргүүн нь эрэгтэй өрхийн 4% нь ийм байна.

Тээврийн хэрэгсэл

Гар тэргийг Борнуурын өрхүүд түгээмэл ашигладаг бөгөөд санамсаргүй түүврийн өрхийн 59% (65) нь гар тэрэгтэй, улирлын нүүдэл хийх, хүнсний ногоо, сүү зах зээлд тээвэрлэхэд ашигладаг байна. Харин дөрвөн дугуй нь мааждаг машинтай өрх цөөхөн байсан ба зөвхөн 5% (6) нь байв. Сумын төвийн Өгөөмөр багын судалгаанд хамрагдсан өрхүүд тээврийн механик хэрэгсэл багатай бүртгэгдсэн.

Ачааны машин, трактор, мосттой тэрэг, машин, мотоцикл, гар тэрэг, морь, чиргүүл гэх мэт тээврийн хэрэгслийн төрлүүд тэргүүн нь эрэгтэй өрхүүдэд илүү байдаг. Доорх 7-р зураглалд асуулгад оролцогчдын эзэмшиж буй тээврийн хэрэгслийн төрлүүдийг харуулав. Жишээ нь, эрэгтэй тэргүүнтэй өрхийн 35% нь машинтай байхад өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн зөвхөн 12% нь машинтай байна. Малчин өрхийн хувьд тээврийн хэрэгсэл чухал хэрэгтэй зүйл байдаг гэдгийг харгалзан үзвэл энэхүү ялгаатай байдал нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн ядуурал, мөн тэдэнд мал маллах хэцүү байдгыг харуулж байна.

Зураглал 7. Борнуур, Өрхийн тэргүүн нь эрэгтэй болон эмэгтэй өрхийн тээврийн хэрэгслийн төрлүүд



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суруу судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Ерөнхийдөө, ЭГЭЭББ төслийн суурь судалгааны орон сууцны төрөл, материалууд, өмч хөрөнгө, цахилгаан, ус, ариун цэврийн хангамж, тээврийн хэрэгсэл зэрэг мэдээллүүдээс харахад Борнуурын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийн ядуурлын түвшин өндөр байна гэсэн

дүгнэлтэд хүрч байна. Ялангуяа өрх толгойлсон малчин эмэгтэйтэй өрхийн хувьд тун эмзэг болох нь харагдаж байна. Энэхүү дүгнэлтийг оролцооны аргаар хийсэн судалгаа мөн баталж байгаа бөгөөд ялангуяа бага насны хүүхдүүдтэй бэлэвсэн эмэгтэйчүүд ядуурах аюултай байдаг тухай бид дараагийн сэдэвт үзнэ.

Үндсэн амьжиргаа

Сумын төвд хотжилт хурдан явагдсан, газар хувьчилсан, бэлчээрийн газар талхлагдаж байна гэж үзэх болсон зэрэгтэй уялдаад Борнуурын зарим хүмүүс уламжлалт мал аж ахуйгаа орхиж хагас болон бүрэн эрчимжсэн мал аж ахуй эрхлэх болсон. Мөн зарим тохиолдолд тариаланчид хүнсний ногоо тарихийн хажуугаар дунд хэмжээний тэжээлийн тариалан эрхлэх болжээ. Хашаандаа малаа хариулж зөвхөн тэжээлээр тэжээдэг орчин үеийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчидтэй адилгүй уламжлалт малчид зун цагт бэлчээрээс хамааралтай, өвлийн улиралд хадлангаас хамааралтай хэвээр байна.

Ашиглах болон эзэмших эрхтэй талбай дээр тэжээлийн ургамал тарьдаг бол намрын цагт нийтийн эзэмшлийн бэлчээрээс хадлан авдаг. Гэхдээ Борнуурт хадлан хийх сайн бэлчээр хомс, бэлчээр хашиж авсан тохиолдлууд их гарч байгаа учир энэхүү үнэтэй нөөцийн талаар маргаан их гарах болсон байна. Энэ тухай дараагийн сэдвүүдэд үзнэ. Мөн бидний ЗБУ, ХХЯ-д оролцогсод олон залуу хүмүүс мал маллах сонирхолгүй болж, Борнуурт ажлын байр хомс учир Улаанбаатар руу ажил хайхаар нүүсэн, харин зарим нь сумандаа гар аргаар алт олборлох болсон тухай ярьсан юм.

Ер нь Борнуурт амьжиргааны олон төрлийн эх үүсвэр байгаа нь харагдаж байна. Олон өрх мал маллах, тариалан эрхлэх хоёрыг хослуулдаг, эсхүл өрхийн нэг гишүүн нь албан ёсны ажилтай байна. Бидний суурь судалгаагаар санамсаргүй түүврийн өрхийн 56% (62 өрх) нь “малаа малладаг” өрхийн гишүүнтэй, 18% (20 өрх) нь “албан ёсны ажилтай” өрхийн гишүүнтэй байсан.

Суурь судалгааны тэргүүн нь эрэгтэй өрхийн жаран гурван хувь нь (82 өрхийн 52 нь) малаа малладаг өрхийн гишүүнтэй, 18% (82 өрхийн 15 нь) албан ёсны ажилтай гишүүнтэй байхад өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 37% (60 өрхийн 22 нь) нь малаа малладаг өрхийн гишүүнтэй, харин 23% (60 өрхийн 14) нь албан ажилтай өрхийн гишүүнтэй байсан. Санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн дөрөв нь бусдад мөнгөөр тариалангийн ажил эрхэлдэг гишүүнтэй байсан бол хоёр нь бусдын малыг мөнгөөр хариулахад оролцдог гишүүдтэй байсан. Энэ нь өрхүүд биеийн хүчний цаг зуурын ажилд бараг оролцдоггүй, харин гэр бүлийн хөдөө аж ахуйн ажилд (биеийн хүчний юмуу ижил төстэй ажил) их оролцдог болох нь харагдсан. Зөвхөн тэргүүн нь эрэгтэй хэдэн өрх газар түрээсэлж тариа тарьдаг гэсэн бол эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн аль аль нь том хэмжээний арилжааны зорилготой тариалангийн талбайд ажилладаг өрхийн гишүүдтэй байсан.

Нийтдээ, санамсаргүй түүврийн өрхийн 23% нь сүүлийн 12 сарын турш зөвхөн нэг мөнгөн орлогын эх үүсвэр, 25% нь хоёр, 31% нь гурав, 12% нь дөрөв, 6% нь дор хаяж таван мөнгөн орлогын эх үүсвэртэй байсан. Харин эрэгтэй, эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүдийн хувьд хоорондын ялгаа бага байсан. 3-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Борнуур сум, Судалгаа авсан бүх өрхийн мөнгөн орлогын эх үүсвэрийн тоо

Мөнгөн орлогын эх үүсвэрийн тоо	Байхгүй	1	2	3	4	5 болон түүнээс дээш	Нийт
Өрх толгойлсон эмэгтэйтэй	1 (2%)	17 (28%)	17 (28%)	19 (32%)	2 (3%)	4 (7%)	60 (100%)
Тэргүүн нь эрэгтэй өрх	0	16 (20%)	21 (26%)	26 (32%)	15 (18%)	4 (5%)	82 (100%)

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суруу судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн зөвхөн 33% (37) нь сүүлийн 12 сарын турш мал аж ахуйгаас олсон мөнгөн орлого нь хамгийн их байсан ба эдгээр 37 өрхийн 41% -ийн өрхийн тэргүүн нь Борнуурт насанд хүрээд нүүж ирсэн хүмүүс байв. Хоёр хөдөөний баг Бичигт багын санамсаргүй түүврийн өрхийн тавин есөн хувь (16), Нарт багын 56% (14) нь тус тус мал аж ахуйгаас олсон мөнгөн орлого хамгийн их байсан. Санамсаргүй түүврийн өрхийн арван долоо нь (15%) сүүлийн 12 сард газар тариалангаас, хоёр өрх уул уурхайгаас хамгийн их мөнгө орлого олсон гэж мэдэгдсэн. Харин 20 өрх (18%) –н тэтгэврийн орлого хамгийн их мөнгөн орлого нь байв. 4-р хүснэгтэд суурь судалгаанд оролцсон бүх өрхийн хамгийн их мөнгөн орлого олсон эх үүсвэрүүдийг жендерээр харуулж байна.

Хүснэгт 4. Борнуур сум, судалгаанд оролцсон бүх өрхийн хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр

Хамгийн их мөнгөн орлогын эх үүсвэр	Өрх толгойлсон эмэгтэйтэй өрх	Тэргүүн нь эрэгтэй өрх
Мал аж ахуй	12 (20%)	31 (38%)
Тэтгэвэр	21 (35%)	10 (12%)
Газар тариалан	1 (2%)	16 (12%)
Төрийн ажил	8 (13%)	6 (7%)
Хувийн бизнес (төрөл тодорхойгүй)	3 (5%)	9 (11%)
Групп	4 (7%)	1 (1%)
Фермер (төрөл тодорхойгүй)	2 (3%)	3 (4%)
Уул уурхай	1 (2%)	2 (2%)
Тэжээгчээ алдсаны тэтгэмж	2 (3%)	-
Дэлгүүрийн туслах	1 (2%)	1 (1%)
Тогооч	1 (2%)	-
Талбайн ажилтан	1 (2%)	-
Сүүний машины жолооч	-	1 (1%)
Бизнесийн эзэн (Засварын газар)	1 (2%)	-
Хувийн бизнес (ресторан)	-	1 (1%)
Хувийн бизнес (супермаркет)	1 (2%)	-
Мэдэгдэхгүй	-	1 (1%)
Орлогогүй	1 (2%)	-
Нийт	60 (100%)	82 (100%)

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн сурууь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйтүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

4-р хүснэгтэд эрэгтэй өрхийн тэргүүнтэй нийт өрхийн 38% (31) нь сүүлийн 12 сарын турш мал аж ахуйгаасаа хамгийн их мөнгөн орлого олсон байхад өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хувьд зөвхөн 20% (12) байна. 29 өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн хувьд 6 өрх нь (21%) нь мал аж ахуйгаас хамгийн их орлого олсон хэмээн мэдэгдсэн. Үүнийг сумын хэмжээнд шилжүүлж тооцвол Борнуурын 77 өрх толгойлсон эмэгтэйтэй өрх болж байгаа бөгөөд хөдөөгийн эмзэг өрхүүдийн хувьд энэ нь бага тоо биш юм.

Бидний хийсэн ЗБУ, ХХЯ-аас харахад ерөнхийдөө өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийн гол амьжиргаа мал аж ахуй, газар тариалангаас бага хамаарч байгаа нь уламжлал ёсоор эдгээр нь эрэгтэй хүний хийдэг ажил байсантай холбоотой юм.

Насанд хүрсэн эмэгтэйтүүд илүү төрийн ажилтай эсхүл ямар нэгэн албан ажилтай (сүргүүл, эмнэлэг гэх мэт) байгааг тэдний боловсролын түвшин эрэгтэйтүүдийнхээс илүү байгаатай холбож үзэж болох юм. Мөн нэгэн сонирхолтой зүйл нь санамсаргүй түүврийн өрхүүдийн нийт эмэгтэй гишүүдийн 51% нь (эмэгтэйтүүд, охидууд) сүүлийн 12 сард мөнгөн орлого олсон бол эрэгтэй гишүүдийн зөвхөн 42% (эрэгтэйтүүд, хөвгүүд) нь мөнгөн орлого олсон байх юм.

Манай судалгаанд оролцсон өрхийн гишүүдийн сүүлийн 12 сард олсон мөнгөн орлогын хэмжээ 32,000 төгрөгнөөс (15 ам.доллар) 33,900,000 төгрөг (15,550 ам.доллар) байв. Энэ нь эрэгтэй тэргүүнтэй малчин өрхийн хувьд ч адил. Сүүлийн 12 сард олсон мөнгөн орлогын хамгийн их

тавынх нь дөрвийг нь эрэгтэй тэргүүнтэй малчин өрхүүд олсон бөгөөд 3 өрхийн тэргүүлэгч уг мөнгийг олсон эсхүл авсан, харин 1 өрхийн эхнэр нь мөнгө олсон эсхүл авсан байна.


Тав дахь хамгийн их мөнгөн орлогыг өрх толгойлсон эмэгтэй супермаркетийн бизнесээсээ олсон байсан бөгөөд энэ нь зориудаар нэмж судалгаанд оруулсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байв.

Газар тариалангаас мөнгөн орлого олсон нь бүгд эрэгтэй тэргүүнтэй өрхүүд байсан ба 140,000 төгрөгнөөс (64 ам.доллар) 8,000,000 төгрөгний (3,670 ам.доллар) хооронд байв. Өгөөмөр багын нэг эрэгтэй өрхийн тэргүүнтэй айл гар аргаар алт олборлож (хууль бусаар) 10,000,000 төгрөг (4,587 ам.доллар) сүүлийн 12 сарын хугацаанд олсон нь судалгаанд оролцсон өрхүүдийн уул уурхайгаас олсон хамгийн их орлого байв. Алт олборлодог өрхүүдийн жилийн орлогын хэмжээ 100,000 төгрөгнөөс (46 ам.доллар) 3,000,000 төгрөгний (1,346 ам.доллар) хооронд байв. Зориудаар нэмж судалгаанд оролцуулсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдээс зөвхөн гурав нь өрх алт олборлолтоос олдог орлогын хэмжээ 180,000 (83 ам.доллар) - 500,000 төгрөгийн (229 ам.доллар) хооронд бага байсан ба санамсаргүй түүвэрт ийм өрх байгаагүй.

Борнуурын хувьд зөвхөн нэг айл ерөөсөө мөнгөн орлого олоогүй гэж хариулсан ба энэ нь санамсаргүй түүвэрт багтсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх байлаа.

Дээр дурьдсанчлан Монгол улс ардчилалд шилжих шилжилтийн үеийн Борнуур замын ажилгүйдлийг гар аргаар алт олборлох үйл ажиллагаа үндсэндээ орлосон гэж хэлж болно. Иймд 2016 оны талбарын судалгаагаар сумын өрх бүрийн дор хаяж нэг гишүүн ямар нэгэн байдлаар урьд нь алт олборлох ажилд холбоотой байсан эсхүл холбоотой байсан. Гэхдээ уул уурхайн орлого хамгийн их мөнгөн орлого авчирдаг амьжиргааны төрөлд орохгүй болох нь суурь судалгаагаар харагдсан. 4-р хүснэгтэд үзүүлэв. Санамсаргүй түүврийн өрхүүдийн зөвхөн 14 % (16) нь алт олборлох ажил хийдэг гишүүнтэй. Тэдний ихэнх нь (14) нь хууль ёсны болон хууль бус (нинжа) алт олборлолт явуулдаг байна. 8-р зураглалд тэдний хийдэг уул уурхайн ажлын төрлүүдийг харуулсан ба өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, тэргүүн нь эрэгтэй өрхүүдээр ялгаж харуулав.

Зураглал 8. Борнуур сум, Судалгаанд хамрагдсан өрхүүдийн уул уурхайн ажилд холбогдсон байдал



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн сурууь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Энэхүү зураглалд үзүүлснээр өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 20% (60 аас 12 нь), тэргүүн нь эрэгтэй өрхийн 16% нь (82 өрхийн 13 нь) алтанд явдаг ядаж нэг гишүүнтэй байв. Ихэнх өрхүүд уул уурхайн компанид албан ёсны ажил хийх, цаг зуурын ажил хийхээс илүүтэйгээр гар аргаар, хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа явуулдаг байна. Гэхдээ бидний ЗБУ, ХХЯ-аар хууль бус гэсэн тодотголтой учир гар аргаар алт олборлох үйл ажиллагаанд хамрагддаг ч мэдэгдээгүй илүү өрх байгаа нь ажиглагдсан. Харин эсрэгээрээ суурь судалгааны өрх толгойлсон эмэгтэйтэй

өрхийн 45% (88-аас 40 нь), тэргүүн нь эрэгтэй өрхийн 33% (54-ын 18) “Энэ сумын ихэнх хүмүүсийн амьжиргаа уул уурхайгаас хамаардаг” гэсэн мэдэгдэлтэй санал нэгдэж байсан.

Борнуур сумын өрхийн амьдралд чухал хувь нэмэр оруулдаг нь эргэлзээгүй байгаа ч уул уурхай мөн хүчирхийлэл, архидалт, эрүүл мэндийн асуудал болон бусад сөрөг зүйлс нэмэгдэх хүчин зүйл болсон юм. Монгол орны хаана ч байдал ийм л байгаа бөгөөд дараагийн сэдэвт дэлгэрэнгүй үзнэ.

Мал аж ахуй

5-р хүснэгтэд суурь судалгааны санамсаргүй түүвэрт багтсан өрхүүдийн сүүлийн 12 сарын турш олсон хамгийн их мөнгөн орлогын таван төрөлд мал аж ахуй орж байсан нийт 63 өрхийн мал аж ахуйн орлогын төрлүүдийг харуулсан. Санамсаргүй түүврийн өрхийн 56% нь сүүлийн 12 сарын турш мал аж ахуйгаас ямар нэгэн мөнгөн орлого олж байсны 76 % (48 өрх) сүү, 52% (33 өрх) ноолуур, 29% (18 өрх) мах түс түс худалдсан байна.

Хүснэгт 5. Борнуур сум, Санамсаргүй түүврийн өрхүүдийн мал аж ахуйгаас олж буй орлого


Мөнгөн орлогын эх үүсвэр	Өрхийн тоо	Малтай өрхүүдийн мал аж ахуйгаас олж буй ямар нэгэн мөнгөн орлогын хувь хэмжээ
Мал маллах – сүү	48	76%
Мал маллах – ноолуур	33	52%
Мал маллах - мах	18	29%
Мал маллах - ноос	7	11%
Мал маллах – тодорхойгүй	3	5%
Мал маллах – морь худалдах	1	2%
Мал маллах – малын худалдаа	1	2%
Мал маллах – тэжээл худалдах	1	2%

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. N = 63.

Бусад өрхүүд малтай боловч сүүлийн жилд мөнгөн орлого олоогүй хэрэгцээндээ ашигладаг гэж мэдэгдсэн. Мандал, Өгөөмөр багын хашаандаа цөөн тооны малтай, хагас эрчимжсэн болон эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа өрхүүд, эсхүл хөдөө малаа хамаатнаараа хариулуулдаг өөрсдийгөө малчин хүмүүс гэж үзэхгүй байсан. Суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 75% (83) нь өөрсдийн хэрэгцээндээ зориулж мал аж ахуй эрхэлдэг байна. Харин 51% (57 өрх) нь сүү, сүүн бүтээгдэхүүн худалдаалдаг, 29% (32 өрх) малын мах худалдаалдаг байна.

Дараах 9-р зураглалд малаа ашигладаг гэж тайлагнасан өрх толгойлсон эмэгтэйтэй бүх өрх, тэргүүн нь эрэгтэй бүх өрхүүдийг ялгаж харуулав. Үүнд өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдээс илүүтэйгээр тэргүүн нь эрэгтэй өрхүүд мал аж ахуйгаас илүү хамаарч байгаа- хэрэгцээндээ болон/эсхүл мөнгөн орлого олдог болохыг дурьдах нь зүйтэй. Мөн уламжлалт нийгмийн ёс зүй буюу эмэгтэй хүмүүс мал муулдаггүй гэсэн уламжлалтай холбоотойгоор маш цөөхөн өрх толгойлсон эмэгтэйтэй өрх малын махаа худалдаалж орлого олдог байна. Энэ тухай дараагийн сэдэвт үзнэ.

Зураглал 9. Борнуур сум, Судалгаанд хамрагдсан өрхийн мал болон бусад амьтдын хэрэглээ



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Борнуур сумын өрхүүд ихэнхдээ үхэртэй, энэ нь санамсаргүй түүврийн өрхийн 72% (80) бөгөөд тэдний зөвхөн 4 нь 50 аас дээш үхэртэй байв. Бас хонь, ямаатай санамсаргүй түүврийн өрхийн 45% (50) хоньтой, 43% (48 өрх) ямаатай байв. Борнуурын хамгийн олон малтай айл нь эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрх бөгөөд тэднийх 251-350 хоньтой байв. 6-р хүснэгтэд харуулсанчлан мал аж ахуйн янз байдал нь сумын хэсэг бүрээс хамаарч өөр өөр байв. Жишээ нь Нарт багын санамсаргүй түүврийн өрхийн 92% (23) үхэртэй, 68% (17) нь ямаатай, 60% (15) нь хоньтой байв. Мандал багын хувьд хагас эрчимжсэн мал аж ахуй голлосон ба 69% (180) нь үхэртэй байхад Өгөөмөр баг энэ нь 45% (15) байв.

Хүснэгт 6. Борнуур сум, Санамсаргүй түүврийн малтай өрхийн тоо, хувь

Баг	Үхэр		Хонь		Ямаа		Адуу	
	Өрхийн тоо	Багын өрхийн тоонд эзлэх хувь	Өрхийн тоо	Багын өрхийн тоонд эзлэх хувь	Өрхийн тоо	Багын өрхийн тоонд эзлэх хувь	Өрхийн тоо	Багын өрхийн тоонд эзлэх хувь
Бичигт	24	89%	17	63%	16	59%	13	48%
Мандал	18	69%	13	50%	11	42%	5	19%
Нарт	23	92%	15	60%	17	68%	14	56%
Өгөөмөр	15	45%	5	15%	4	12%	3	9%

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ Бичигт баг N = 27, Мандал баг N = 26, Нарт баг N = 25, Өгөөмөр баг N = 33.

Борнуурт Улаанбаатарын гурван сүүний үйлдвэрийн сүү цуглуулах цэг байдаг бөгөөд малчид, фермерүүд сүүгээ тушаадаг. Харин хүнсний ногоо, махыг ихэвчлэн Улаанбаатар руу шууд худалдан борлуулдаг. Суман дээр ихэвчлэн эмэгтэйчүүд сүү худалддаг байхад эрэгтэйчүүд Улаанбаатар руу очиж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ шууд борлуулдаг. Гэхдээ эмэгтэйчүүд ийм ажлыг зохион байгуулдаг бөгөөд мөн тэд өрхийн мөнгөн орлогыг хадгалж, өрхийн санхүүгийн асуудлыг зохицуулдаг уламжлалтай байна. Үүнийг дараагийн сэдэвт дэлгэрэнгүй үзнэ.

Бидний суурь судалгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн мал аж ахуйн ажлын хөдөлмөрийн хуваарийг нарийвчлан гаргасан. Санамсаргүй түүврийн өрхийн 50% (56) –д эмэгтэйчүүд сүү саадаг бол зөвхөн 14% (15 өрх) –д нь өрхөд эрэгтэйчүүд оролцдог байна. Үүний адилаар сүү боловсруулах, бэлтгэх ажлыг ихэвчлэн эмэгтэйчүүд буюу санамсаргүй түүврийн өрхийн 46 % (51) –д нь эмэгтэйчүүд хийдэг байхад эрэгтэйчүүдийн 5% (6 өрх) байна. Хүүхдүүд сургуульд яваагүй үедээ мал маллахад тусалдаг – бүх санамсаргүй түүврийн өрхийн 23% (26 өрх). Өрхүүд зарим үед гадны хүнээр туслуулдаг – санамсаргүй түүврийн өрхийн 14 % (16 өрх) өрхийн

гишүүн бүс хүнээр сүүн бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах ажлыг хийлгэдэг байна. Харин малаа муулдаг эмэгтэй хүн байхгүй байсан. Малын мах зардаг эсхүл хүнсэндээ мах хэрэглэдэг эмэгтэйчүүд өрхийнхөө эрэгтэй хүнийг гуйж малаа муулуулдаг эсхүл амьдаар нь зардаг байна.

Газар тариалан

Бидний суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 56 (50%) нь Борнуурт газар тариалан эрхэлдэг хэмээсэн. Тэдгээр өрхийн тариалалт хийсэн талбайн дундаж хэмжээ 3.25 га бөгөөд үүнд Өгөөмөр багт байрлах Борнуурын иргэдэд хуваан олгосон усалгаат тариалангийн 1-2 га ногооны талбай багтана (ойролцоогоор нийт 1000 га). 1990 оны хувьчлалын үеэр ашиглах, эзэмших эрхтэйгээр энэ газрыг олгосон байдаг. Үүнээс гадна Бичигт баг усалгаагүй талбай, Нарт багт социализмын үед хуучин усалгаатай байсан талбай мөн тариалангийн талбайд багтах бөгөөд хүмүүс голоос үс авдаг. 7-р хүснэгтэд тариалангийн талбайн хэмжээг багуудаар харуулав. Нарт багын өрхүүдийн дунд том хэмжээтэй тариалангийн талбайтай өрхийн тоо их байв.

Хүснэгт 7. Борнуур сум, санамсаргүй түүврийн газар тариалан эрхэлдэг өрхүүдийн тариалалт хийсэн талбайн дундаж хэмжээ (га –аар)


Баг	Тариалалт хийсэн буй талбайн дундаж хэмжээ (га)
Бичигт	2.6
Мандал	2.85
Нарт	8.43
Өгөөмөр	1.97
Борнуурын дундаж	3.25

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ N = 56.

Нийт 56 өрхийн 182 га –д тариалалт явуулж байгаа гэсэн тоо гарсан. Үүнийг сумын хэмжээнд шилжүүлэн тооцвол нийт 2,275 га –д 708 өрх тариалалт явуулж байгаа тооцоо гарч байна.

Олон төрлийн ногоог өрхүүд тариалдаг ч ихэвчлэн төмс, лууван, тэжээл, сонгино тариалдаг байна. Дээр өгүүлсэнчлэн, Социализмын үед төрөөс Борнуур сумыг төмсний орон болгох бодлого барьдаг байсан бол одоо мөн байцаа, лууван, сонгино их тарьдаг болжээ. Газар тариалан эрхэлж буй санамсаргүй түүврийн 56 өрхийн наян хоёр хувь (46 өрх) нь төмс, 57% (32) сонгино, 36% (20) тэжээл, 28% (16) лууван тарьсан байна. Дөрвөн багаас усалгаатай талбайтай Өгөөмөр багын өрхүүд төрөл бүрийн ногоо тарьдаг байна. Үүнийг 10-р зураглалд харуулав.

Зураглал 10. Борнуур сумын багт бүрт тариалдаг тариа, ногооны төрөл




Эх сурвалж: ЭГЭЭББ суурь судалгаа, 2016. N = 56.

Борнуурын өрхүүд тариа, ногоогоо ихэвчлэн өрхийн хэрэгцээндээ ашигладаг. Санамсаргүй түүврийн өрхийн дөчин дөрвөн хувь (49 өрх) нь өрхийн хэрэгцээндээ зориулан ногоо тарьдаг, 33% (37 өрх) мөнгө олохын тулд, 19% (21) нь малаа тэжээхийн тулд, 49% (54 өрх) нь огт тариалан эрхэлдэггүй байсан. Нэг өрх энэ асуултад хариулаагүй боловч Борнуурт тариалан эрхэлдэг 56 өрхийн 85% нь өрхийн хэрэгцээндээ ашигладаг гэсэн байна.

Бидний хийсэн ЗБУ, ХХЯ-гаар арилжааны зорилгоор тариалахыг (ихэвчлэн төмс, сонгино, лууван) эрэгтэйчүүдийн ажил гэж үздэг болох нь тодорхой байсан. Учир нь үүнд машин техник шаардагддаг, хүнд хөдөлмөр шаарддаг учир өрх толгойлсон эмэгтэйтэй өрх эрхлэхэд хэцүү гэж үздэг. Үүнийг суурь судалгааны үр дүн баталж байгаа. Өрх толгойлсон эмэгтэйтэй нийт 60 өрхийн 75% нь ямар нэгэн тариалан эрхэлдэггүй гэсэн байхад тэргүүн нь эрэгтэй 82 өрхийн 41% нь ийм байна. 11-р зураглалд тариалан эрхэлдэг өрхийн тариалангийн ашиглалтын байдлыг харуулав. Нэгэн сонирхолтой зүйл нь өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдийг тэргүүн нь эрэгтэй өрхүүдтэй харьцуулахад ашигладаг төрөл цөөн байна.

Зураглал 11. Борнуур сум, Судалгаанд оролцсон бүх өрхийн тариалангийн бүтээгдэхүүний ашиглалт



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн сурууь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Манай ЗБУ, ХХЯ-нд оролцогсод Борнуурт арилжааны зорилгоор тариалалт хийж буй том талбайтай хүмүүс тариалалт, хураалтын үеэр хүмүүс хөлслөн ажиллуулдаг гэсэн. Улирлын чанартай хөдөлмөр эрхлэгчдийг хэд хэдэн төрөлд хувааж үзэж болно. Тогтсон орон гэргүй тэнэмэл ажилчид, нэн ядуу хүмүүс (өөр мөнгөн орлогогүй, архичид гэх мэт), зун цагт мөнгөн орлого олох сонирхолтой оюутнууд болон залуучууд. Оюутан, залуучуудыг ихэвчлэн сургуулийн захиргаанаас том үйлдвэрлэгчидтэй гэрээлэх маягаар зохион байгуулдаг.

Жендерийн харилцаа

Борнуурын эмэгтэйчүүд ихэвчлэн гэр орны ажил хийх, хүүхдээ асрах, малаа саах ажил хийдэг бол эрчүүд нь биеийн хүчний гадуурх ажил- мал маллах, мал мүүлах, хадлан бэлтгэх, түлээний мод татах, хашаа хороо засах, ферм талбайн механикжсан ажил хийдэг. Жишээ нь манай суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхүүдийн 90% ба 91% -д нь гэрийн хоол хийх, хувцас угаах ажлыг эмэгтэйчүүд хийдэг гэсэн бол (100 ба 101 өрх), өрхийн 29% ба 27% (32 ба 30 өрх) –д эрчүүд хийдэг байна.

Гэхдээ бидний ЗБУ, ХХЯ- аар олон ажлыг гэр бүлийн хүмүүс хамтарч хийдэг болох нь мөн тодорхой болсон. Жишээ нь, эрэгтэй хүн өвс хадаж, эмэгтэйчүүд хүүхдүүд нь бүхал хийх, эрэгтэй хүн машинд ачих, эрэгтэй хүн бууц янзалж байхад эмэгтэй хүн сааль саах, эрчүүд ногооныхаа тайлбай дээр ажиллаж байхад эмэгтэйчүүд тогоо барих, эрэгтэйчүүд уул руу явж

ухаж байхад эмэгтэйчүүд шороо угааж, хоол хийх зэрэг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь их хөдөлмөрлөдөг ч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол гэр орны ажил хийж, хүүхдээ асран хамгаалдаг учир илүү хугацаа зарцуулдаг, ачаалал ихтэй болох нь харагдсан. Мөн эмэгтэйчүүд банкны зээл хөөцөлдөх, газрын бичиг баримт хөөцөлдөх зэрэг хугацаа их зарцуулдаг ажлыг хийдэг байна.

Уламжлалт ёсоор эрэгтэй хүнийг гэрийн тэргүүн гэж үздэг ч эмэгтэй хүн өрхийн шийдвэр гаргахад голлож оролцдог бөгөөд ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс мөн эмэгтэйчүүд эсхүл хамтдаа шийдвэр гаргадаг хэмээн хүлээн зөвшөөрсөн. Харин мал худалдах, муулах зэрэг ажлыг зөвхөн эрчүүд гардан хийдэг байна. ЗБУ, ХХЯ-ын оролцогчид эрэгтэй хүмүүс малтай холбоотой гол гол санхүүгийг шийдвэрийг гаргадаг байхад эмэгтэй хүмүүс өрхийн санхүүгээ зохицуулдаг гэж баталсан. Эрэгтэйчүүд малаа өөрсдөө хариулдаг учир малаа яахаа өөрсдөө мэддэг гэхдээ тэд мал зарах зэргээс олсон мөнгөн орлогыг хэрхэн зарцуулах эрхийг эмэгтэйчүүдэд өгдөг байна. Яагаад гэвэл эмэгтэйчүүд хүүхдэд юу хэрэгтэй, гэрт юу хэрэгтэй байгааг эрэгтэй хүнээс илүү мэдэж байдаг учир гэж хариулсан байна. Мөн эмэгтэйчүүд төсөв баримжаа барих илүү чадвартай байдаг гэжээ.

Эмэгтэйчүүд (ялангуяа гэрлэсэн эмэгтэй) баг болон сумын хуралд илүү оролцдог, 2016 онд биднийг ажиллаж байхад багын засаг дарга болон хурлын төлөөлөгчид хэд хэдэн эмэгтэйчүүд байсан. Гэхдээ Борнуурт хамгийн нэр нөлөө бүхий албан тушаалыг эрэгтэй хүмүүс эзэлдэг. Хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй багын болон бусад хуралд оролцоход хүндрэлтэй байдаг учир тэдний улс төрийн оролцоо сул, болсон чухал зүйлсийг дараагаар нь л мэддэг байна.

Бидний ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс Борнуурт жендерээс шалтгаалсан ямар нэгэн ялгаварлан гадуурхал байхгүй гэж үзсэн бөгөөд дээр тайлбарласанчлан тэд байгалийнхаа ёсоор, харилцан шүтэлцээтэй ажил хийдэг, эрчүүд хүнд хүчир ажил, эмэгтэйчүүд гар орны ажлаа тус тус хийдэг хэмээн зөвшөөрсөн. Гэхдээ нөхөр нь талийгч болоход эмэгтэй хүнд олон асуудал гардаг болох нь тодорхой байсан. Учир нь бэлэвсэн эмэгтэй эрэгтэй хүний болон эмэгтэй хүний ажлын аль альныг нь хийж гүйцэтгэх шаардлага гарч хүнд ажлын ачаалал даах чадваргүй болдог байна. Ялангуяа эр хүний хүч хөдөлмөр шаарддаг тариалан, мал аж ахуй эрхэлдэг хүмүүсийн хувьд ийм байдал илүү үүсдэг. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдэд мөн газар олж авахад хүндрэлтэй байдаг, мөн тэд газрын маргаанд илүүтэй оролцдог болох нь харагдсан. ХХЯ-аас харахад бэлэвсэрсэн эмэгтэй ядууралд өртөх, газар эдэлбэрийн аюултай байдалд ороход ойр хамгийн их эмзэг байдаг байна. Хэд хэдэн бэлэвсэн эмэгтэй тариалангийн газраа эсхүл малаа зарахаас өөр аргагүйд хүрч, өвөлжөөний газраасаа хүртэл явахад хүрсэн тухай ярьсан.

Бидний судалгааны үеэр уул уурхайгаас болж эрчүүд их архи уух болсон тухай олон хүмүүс хөндсөн. Эрчүүд олсон мөнгөө архинд үрж байгаа учир энэ явдал гэр бүлд хор хөнөөлтэй. Монголын тухай хийгдсэн бусад судалгаанд уул уурхай, архидалттай холбоотой гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллийн тухай бид аль ч үед нээлттэй яриагүй. Иймд бидний хувьд жендерт суурилсан хүчирхийлэл жендерийн харилцаанд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэх боломжгүй юм.

Уул уурхайн компаниуд болон бичил уурхай

Одоогийн байдлаар Бичигт багын Сүжигт, Харгана ууланд уул уурхайн ажил явагддаг. 2016 оны байдлаар Харгана уулыг гар аргаар алт олборлогчид өөрсдийн гэсэн газаргүй, уул уурхайн компанийн үйл ажиллагааны хаягдлыг ашиглан явуулж байв. Нэгэн ЗБУ-ын оролцогчид өвлийн улиралд газар хөлдсөн үед алт олборлоход хамгийн тохиромжтой байдаг харин хавар, зундаа үер болох магадлалтай учир аюултай байдаг хэмээн тайлбарласан.

Борнуурт үйл ажиллагаа явуулж байсан зүүн Германы уурхай хаагдахад алтны нөөц ихтэй байсан учир бусад компанийн хөрөнгө оруулалтыг татаж 18 уурхайн лиценз олгосны 12 нь хайгуул, 6 нь олборлолтын лиценз байв. 2011 онд Гол мөрний урсац, бүрэлдэх эх, усны сан

бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай (урт нэртэй хууль) хууль гарсны дараа 2012 оноос хойш лиценз шинээр өгөхөө зогсоосон. 18 лицензийн хоёр нь молибден үлдсэн нь алтных байна.

8-р хүснэгтэд олж авсан мэдээллээ үндэслэн 6 олборлох лиценз, 12 хайгуулын лицензийн 11-ийнх нь хамрах талбайг ойролцоогоор үзүүлэв. Хайгуулын лицензийн тухай мэдээлэл тодорхой бүс байсан. Энэ мэдээллээр бол хамгийн багаар бодоход хоёр төрлийн лицензний хамрах талбай нь нийт сумын нутаг дэвсгэрийн 23% юм.

Хүснэгт 8. Борнуур сум, Уул уурхайн лицензүүдийн хамрах хамгийн бага, хамгийн их талбай (га-аар)

	Хамгийн бага талбай	Хамгийн том талбай	Дундаж хэмжээ	Нийт хэмжээ
Хайгуул	42.22	8,469.72	2,173.64	23,910.04
Олборлолт	4	2,174.58	479.3	2,875.78
				26,785.82

Эх сурвалж : Борнуур сумын зихиргааны мэдээлэл, 2015 оны 3-р сарын 3.

Дөрвөн шинэ хайгуулын лицензийн Сэлэнгэ Минералс эзэмшдэг бөгөөд 14,879 га. Үүнд Нарт уулын 8,497 га –тай хамгийн том эзэмшлийн нэг лиценз, Хараа гол, Арангат, Шар уулын 3 лиценз багтана. Хайгуулын лицензүүдэд Сентерра Голд Монголиа компанийн Өндөр уулын 2,786 га багтана. Үйлдвэрлэлийн зургаан лицензийн Гүн билэгт болон Зуун мод Уул –ын аль аль нь хоёр хоёр лицензтэй бөгөөд үлдсэн хоёр лицензийн Туншан Шиандон, Сентерра Голд хоёр эзэмшдэг. Гэхдээ эдгээр 6 ашиглалтын лицензийн гурав нь л ажиллаж байсан: Бичигт багын Харгана, Сүжигт уулсын Гүн билэгт, Өнжин уулын ойт бүсэд байрлах Сентерра Голдын алтны уурхай. Үйл ажиллагаа бүрэн явагдаж байх үедээ 1,000 гаруй ажилтан, гэрээний ажилчидтай байсан. Гүн билэгт 1998 оноос 2012 он хүртэл (харин Бороо голд 2003 оноос хойш эхэлсэн) ажиллаж алтны орц багатай хүдрийг цианид ашиглан боловсруулдаг байсан ба 2016 он гэхэд үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон гэж ойлгогдож байна. ЗБУ, ХХЯ-н ихэнх оролцогчид эдгээр компаниудын үйл ажиллагааны талаар ямар нэгэн хүрэл зөвлөгөөнд уригдаж байгаагүй, тэд маш багыг мэдэж байлаа. Ихэнх хүмүүс ямар компани байдгыг ч мэдэхгүй байсан. Гэхдээ гадаадууд (хятадууд) эсхүл Улаанбаатарын хүмүүсийг хөлслөн авч ажиллуулдаг хэмээн гомдоллосон юм.


2016 оны бидний ажлын үеэр энэхүү хоёр уул уурхайн компани Борнуур суманд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх эсэх нь тодорхойгүй, лицензтэй бусад компаниудын хувьд ч ялгаагүй хайгуул юмуу олборлолт явуулах нь тодорхойгүй байсан. Гэхдээ, урьд нь ажиллаж байсан уурхайн талбайн аль алинд нь бичил уурхай эрхлэгчдээс хамгаалсан харуул, хамгаалалтынхан ажиллаж байсан. Гэвч, бичил уурхайчид шөнө дөлөөр уурхайн бүсэд нууцаар нэвтэрчихдэг эсхүл харуулуудад харамж өгч ажилладаг бололтой байсан. Манай судалгааны нэг оролцогч хоёр газарт 2016 оны 11 –р сарын байдлаар нийтдээ 30-40 хууль бүс гар аргаар уурхай эрхлэгчид байгаа бөгөөд тав, зургаа нь эмэгтэйчүүд гэж мэдээлсэн юм.

Уул уурхайн нөлөөлөл

Бидний ЗБУ, ХХЯ –д оролцсон хүмүүс уул уурхайн хөрөнгө оруулалт ямар нэгэн ашиг тус авчраагүй, ажлын байр ч нэмэгдүүлээгүй харин нутгийн байгаль, гол мөрөнг бохирдуулсан гэсэн. Ялангуяа голын усаар малаа усладаг малчин өрхүүд энэ талаар их санаа зовж байсан. ЗБУ, ХХЯ-гийн үеэр гар аргаар уул уурхай эрхэлж мөнгөн орлого олж байсан нь ганц ашиг тус хэмээн дурьдаж байв. Гэхдээ олон хүмүүсийн хувьд эрүүл мэндийн эрсдэл нь гар аргаар уул уурхай эрхлэхийн ашиг тусаас хэд дахин сөрөг нөлөөтэй юм.

Санамсаргүй түүврийн өрхийн 28% (31) нь сүүлийн хоёр жилд уул уурхай тэдний амьдралд нөлөөлсөн гэсэн- Өгөөмөр багынхны 33 өрхийн 42%, Нарт багын 25 өрхийн 12% гэх мэт. Харин санамсаргүй түүврийн өрхийн нийтдээ 4% - 6% нь сүүлийн хоёр жилд тусгай хамгаалалттай газар нутаг, том хэмжээний газар худалдан авалт тэдний амьдралд нөлөөлсөн гэсэнтэй харьцуулж болно. 12-р зураглалд санамсаргүй түүврийн өрхийн 14% (16) нь уул уурай тэдний орлогыг нэмэгдүүлсэн гэсэн бол 2% (2) уул уурхай тэдний орлогыг бууруулсан гэсэн. 6% (7) нь уул уурхай өрхийн гишүүдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлсөн гэж тайлбарласан. Харин баг бүрээр нь авч үзвэл хоорондын ялгаа багатай байв. Жишээ нь, Өгөөмөр багын 33 санамсаргүй түүврийн өрхийн 24% нь, Мандалын 26 өрхийн 19% нь уул уурхай өрхийн орлогыг нь нэмэгдүүлсэн гэсэн бол Бичигтийн 27 өрхийн хэнийх нь ч орлогыг нэмэгдүүлээгүй байна. Харин жендерийн хувьд хариултууд их ялгаатай. Бүх эмэгтэй хариулагчдийн гучин найман хувь нь (88 хүний 33), харин эрэгтэй хариулагчдын 24% (54 хүний 13 нь) уул уурхай тэдний амьдралд нөлөөлсөн гэсэн.

Зураглал 12. Борнуур сум, санамсаргүй түүврийн өрхүүдийн уул уурхайн нөлөөлөлд авсан байдал



Эх сурвалж: ЭГЭЭББ суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ N = 111.

12-р зураглалд уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг онцлон гаргаж ирсэн. Үүнд “уул уурхай тоос их гаргаж, газар талхалдаг” (санамсаргүй түүврийн өрхийн 11% (12)), “уул уурхай усны эх үүсвэрийг ширгээж байна”, “нийтийн бэлчээрийн газарт дарамт үзүүлэх нь ихэсч байна” (аль аль нь 12% (13), уул уурхай хаа сайгүй зам гаргаж бэлчээр сүйтгэж, малд аюул учруулдаг” (9% (10)).

Уул уурхайтай холбоотой байгалийн нөөцийн асуудлууд Борнуураас гадна хөрш зэргэлдээх Сэлэнгэ аймгийн Мандал сум, Шарын гол зэрэг сумдад усны эх үүсвэрийг бохирдуулж, байгаль орчныг доройтуулж байгаа явдал гарсан. Гэхдээ Сентера голд-ын ажилтнуудтай ярилцахад тэд байгаль орчны нөхөн сэргээлт хийж байгаа ажил үйлсээрээ бахархдаг хэмээсэн бөгөөд жилд 250,000 ам.долларыг Бороогийн алтны уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд зарцуулдаг гэсэн байна. Энэ мөнгөний 9,875 ам.долларыг тусгайлан 2020 хүртэл үргэлжлэх байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулахаар төсөвлөгдсөн, үр суулгах, мод тарих, услах зэрэгт нутгийн иргэдийг хөлсөлж ажиллуулдаг гэжээ.

Гар аргаар алт олборлох үйл ажиллагааг хууль ёсны болгох нь

1990 –д онд гарсан уул уурхайн мандан бадрал нь социализмын үеийн ажилгүйдлийг нөхөж, ядуурлаас гарахад тусалсан ч олон асуудлыг дагуулсан. Алт олборлох ажил эрхлэх сумын болон гадны хүмүүсийн үрсгал ихэсч, зохицуулалтгүй хууль бус орчинд ажиллаж байснаас үүдэн хүчирхийлэл, биеэ үнэлэлт, байгаль орчин бохирдож, мөнгөн усыг зохицуулалтгүй хэрэглэснээс болж эрүүл мэндийн хувьд эрсдэлд орсон. Энэ мэт олон асуудалд хариулт олох үүднээс 2007 онд Швейцарын хөгжлийн агентлагын туслалцаатайгаар олон талт оролцогч талуудын үүлзалтыг зохион байгуулсан. Энэ хуралд сумын засаг дарга, гар аргаар алт олборлогчид, Сентерра Голд, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, үндэсний иргэдийн хурлын төлөөлөгчид, сумын төлөөллүүд оролцсон. Хурлын үр дүн, мөн ШХА-ын нөлөөтэйгээр 2009 онд Ашигт малтмалын тухай хуулинд өөрчлөлт оруулж гар аргаар алт олборлож буй хүмүүсийг хамтран нөхөрлөл байгуулж сумын захиргаа, уул уурхайн компанитай гурвалсан гэрээ хийж ажиллаж болохыг хуульчилсан.

Бидний ЗБУ, ХХЯ-аар ШХА-ын төслийн үрээр 2008 онд гар аргаар алт олборлогчдын анхны шүхэр байгуулгыг Борнуурт байгуулсан байдаг. Гар аргаар алт олборлогчид Нөхөрлөлд нэгдэж (жилийн татвар төлдөг) нийтдээ гар аргаар уул уурхай эрхлэгчдийн холбоо гэсэн 800 гаруй хүнтэй шүхэр байгууллага байгуулсан. Ингээд гар аргаар уул уурхай эрхлэгчид Борнуурын захиргаа, Сентерра голд, ШХА –тай олон талт оролцогч талын гэрээ байгуулж Сентерра голд компани өөрсдийн лицензтэй газраас хэсгийг нь алт олборлогчдын холбоонд өгсөн. Сумын захиргаа 120 сая төгрөг (55,046 ам.доллар), ШХА 220 сая (88,707 ам.доллар) төгрөг хандивлаж байгаль орчинд ээлтэй, хортой химийн бодис ашиглахгүй алт боловсруулах үйлдвэр барихаар болсон. ШХА-ын зүгээс гар аргын алт олборлолтыг хууль ёсны болгох хуулинд өөрчлөлт оруулахад үнэтэй хувь нэмэр оруулж, алт олборлогчдыг техник, тоног төхөөрөмжөөр хангасан. Монголын ЗГ гар аргаар алт олборлогчид, тэдний түншлэлийг зохицуулах шинэ журам гаргасан.

Гар аргаар алт олборлогчдын боловсруулах үйлдвэрийг хуучин Зүүн Германы уурхайн үлдэгдлээс алт боловсруулах зорилгоор байгуулсан. ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс тэр үед шүхэр байгууллагыг байгуулалцаж байсан хүмүүс мөнгийг авч нөхөрлөлийн бүх хүмүүстэй хэлэлцэлгүйгээр ХАМО хэмээх хувийн компанийн бүтцээр бүртгүүлсэн хэмээсэн (ХАМО-хувиараа ашигт малтмал олборлогчид). Ингээд ХАМО нөхөрлөл бүртэй алтны хүдрийг угаах, бутлах, боловсруулалт хийх гэрээ хийсэн. Хүдрийг ихэнхдээ хоёроос гурван удаа угаах, эхний угаалтыг алт олборлогчдод, хоёр дахь болон гурав дахь угаалтыг ХАМО авах гэрээ хийсэн. Мөн хоёр дахь болон гурав дахь угаалтын ашгийн 30% -ийг нөхөрлөлийн бүх гишүүдэд хуваарилахаар болсон. Мөн ХАМО алт олборлогчдоос хувиараа шууд хамгийн бага үнээр худалдан авдаг болсон.

Мөнгөн үс зэрэг хортой бодисыг ашиглах нь багассан, гар аргаар алт олборлох явдал илүү зохион байгуулалттай болсон, хүчирхийлэл буурсан боловч олон уурхайчид ялангуяа, гүний усны бохирдол, тоос шороо гаргах зэрэг ХАМО-гийн байгаль орчинд үзүүлэх хор хөнөөлийн талаар санаа зовниж буйгаа илэрхийлж байсан. Мөн ХАМО их ашиг олж нөхөрлөлүүдтэй хийсэн гэрээний дагуу тараахгүй байгаа байх гэсэн сэтгэгдлээр ХАМО-д хууртагдаж байгаа талаар илэрхийлсэн. Орон нутгийн уурхайчдын холбооны мониторингийн захирлын хэлснээр ХАМО-гийн ашиг 2 тэр бум төгрөгт (917,431 ам.доллар) хүрсэн боловч зөвхөн 60 саяыг гишүүддээ болон нөхөрлөлүүддээ 2015 онд тараасан байна. 2015 оны сүүлээр ХАМО түр зуур ажиллахаа зогссон боловч 2016 оны сүүлээр дахин ажиллаж эхэлсэн.

Буцаад хууль бус үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь

Дээр өгүүлсэнчлэн 2016 онд биднийг ажиллаж байх үед Борнуурт уул уурхайн томоохон компаниуд ажиллаагүй. Мөн шороон ордны алтны хувь хэмжээ буурч байгаа учир гар аргаар олборлолтын ашиг буурсан гэсэн хандлага бий болсон. ЗБУ, ХХЯ-ын үеэр олон талт оролцогч талын хуралдаанаар Бороо голд компанийн гар аргаар ашигт малтмал олборлогчдын холбоонд

өгсөн газрыг уурхайчидтай хэлэлцэж, зөвшөөрлийг нь авалгүйгээр өөр компанид (Гүн билэгт) худалдсан. Энэ газарт шинэ өмчлөгч үйл ажиллагаа явуулж эхлээгүй байгаа боловч харуул гаргаж гар аргаар олборлолт хийгчдийг оруулахыг хориглосон гэж бидэнд мэдээлсэн. Үр дүнд нь Борнуурын гар аргаар алт олборлож байсан олон хүмүүс үйл ажиллагаагаа зогсоож, зарим нь хууль бусаар алт олборлож эхэлж байна. Мөн ХАМО “хууль бусаар” алт ухсан хүмүүсийн алтыг боловсруулж байгаа сурагтай байна. Хүмүүс ХАМО-д гомдолтой байгаа ч тэдний амьжиргаа энэхүү компаниас ихээхэн шалтгаалж байна.

Гар аргаар ашигт малтмал олборлогчид дахин хууль бус гэсэн статустай болсон нь тэднийг нийгмийн хамгаалалгүй болгож байгаа бололтой. Компанийн зүгээс (Бороо голд компанийн менежертэй хийсэн ярилцлагаар онцлон хэлснээр) урт хугацааны шийдэл олох гэсэн ШХА-ын хүчин чармайлт гаргасан хэдий ч гар аргаар алт олборлогчид, сумын захиргаатай гурвалсан гэрээ хийх нь тийм түстэй зүйл биш. Учир нь компанийн лицензтэй газарт гар аргаар алт олборлолт хийснээр гарч болох байгаль орчны доройтол юмуу ямар нэгэн осол гэмтэл гарахад хариуцлага хүлээх болно гэж үзэж байна.

Бидний судалгаагаар тодорхой болсон зүйл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь урьд нь уул уурхайн ажилд оролцдог байсан бол одоо ихэвчлэн ажилгүй залуучууд амьдралын шаардлагаар шөнийн цагаар харуулуудад хахууль өгч ууланд гардаг болсон. Тэд ямар нэгэн мөнгөн орлого олбол ихэвчлэн амьжиргаандаа гэхээс илүү архинд зарцуулдаг болсон байна. Харин урьд нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтдаа уурхай эрхэлж байхдаа амьжиргаандаа илүү зарцуулдаг байсан. Зарим өрх толгойлсон эмэгтэйчүүд хууль бусаар алт олборлолт явуулсаар байна. Хэрэв тэд баригдвал цагдаа болон байгаль хамгаалагчид тэдний тоног төхөөрөмжийг хураан авдаг ба зарим харуулууд эмэгтэйчүүдээр хувцасаа угаалгадаг гэж зарим эмэгтэй уурхайчид дурьдсан.

Эрэгтэй уурхайчдын дунд архидалд өсч, урьдын болон одоогийн уурхайчид эрүүл мэндийн асуудалтай болсон хэмээн ЗБУ, ХХЯ – ын оролцогчид Борнуурын цэргийн албанд тохирох эрүүл залуу хүн олдоогүй гэж байсан.

Орон нутгийн уурхайчдын холбооны мониторингийн захирлын хэлснээр Борнуурын 27 гар аргаар уул уурхай эрхлэгчид уушигний хавдар өвчин түсч өөд болсон тухай 2016 онд ярьж байсан. Мөн 82 хүний бие муу байгаа бөгөөд хууль бусаар ажиллаж байсан тэдэнд компанийн эрүүл мэндийн даатгал байхгүй.

Газрын хомсдол, газрын төвлөрөл, байгаль орчны талхагдал

2016 оны ажилаар газрын хомсдол, газрын төвлөрөл, байгаль орчны талхагдал өсч байгаа дүр зураг гарсан байна. Гэхдээ ажилгүй залуу эрэгтэйчүүд уул уурхайн үйл ажиллагаа руу тэмүүлэх болсон нь тэдэнд орон сууц, тариалан эрхлэх, хадлангийн гэх мэт газар олдох боломж бага байдагтай нь холбон үзэж болно. Бидэнд мэдээлснээр, сумын захиргаанаас олгох орон сууц, хашааны газар байхгүй, ногооны усалгаат талбайд мөн илүү газар байхгүй гэх мэ бүх газар эзэнтэй болсон байна. Гэхдээ газрын зах зээл хурдацтай өсч байгаа учир мөнгөтэй хүмүүс газар түрээслэх эсхүл худалдан авч янз бүрийн зорилгоор ашиглах боломжтой болж байгаа бололтой. Жишээ нь, жуулчны бааз байгуулах эрэлт их байдаг ба Нарт багын (Дугана хадны ойролцоо) 16,500 га түсгай хамгаалалттай газарт зургаан жуулчны бааз байгуулагдчихсан байна. Зарим иргэд газраа Улаанбаатарын хувь хүмүүст, компанийн хөрөнгө оруулагчдад худалдсан байна; 2002 оны газрын тухай хуулийн дагуу аймаг, сумын захиргаанаас дуудлага худалдааны хэлбэрээр аялал жуулчлалын зорилгоор 400 га газрыг хөрөнгө оруулагчдад худалдаж орон нутгийн төсөвт оруулсан байна. Сумын газрын даамлын хэлснээр, ийм төрлийн дуудлага худалдааг 0.07 га –с илүү газар авах хүсэлт гаргасан тохиолдолд явуулдаг ба сумын захиргаа ашиглагдаагүй газрыг дуудлага худалдаанд оруулж, хамгийн их үнэ хэлсэн хуулийн этгээдэд өгдөг байна. Ингэж гадныхан ирж суманд газар авч болдог байна.

Газрын хомсдол, газрын зах зээлийн хөгжлийг дагаад газрын гэрчилгээжүүлэлт нэмэгдсэн. Хашааны газар, хүнсний ногоо, тэжээлийн тариалангийн талбайд хөрөнгийн өмчлөх, эзэмших гэрчилгээ өгдөг боловч бэлчээрийн газар нийтийн өмч хэвээр байсаан байна. Хадлангийн газрыг сумын захиргаанаас ашиглах эсхүл эзэмших эрхгүйгээр кадастрийн зураг хийж айлуудад саяхнаас олгосон байна. Энэ тухай бид дараагийн сэдвүүдэд үзэх болно.

ЗБУ, ХХЯ-ны оролцогчид албан ёсны газар өмчлөл эрх тэгш бус явагддаг гэж үздэг байна. Нарт багт цөөн хэдэн чинээлэг хувь хүмүүс уул уурхай, хадлан, ферм, аялал жуулчлалын газрын том талбай эзэмшдэг (эзэмшлийн юмүү түрээсээр), ялангуяа хүнсний ногооны, ногоон тэжээлийн талбайг бэлчээрийн газар дээр авсан байдаг. Ингэснээр малчид, тариаланчдын хоорондын маргаан гарах үндэс болдог байна. Харин бусад ядуу хүмүүс хөрөнгийнхөө гэрчилгээг – эзэмших, ашиглах эрх авч чадахгүй байсан байна. Улсын хэмжээгээр авилга их байдагтай холбоотойгоор зарим хүмүүс таагүй байдлаа илэрхийлж, ядуу дорой хүмүүсийг ялгаварлан гадуурхдаг гэж үздэг байна.

Дээр өгүүлсэнчлэн Монгол улс дахь шилжилтийн үеэр гадны олон хүмүүс Борнуурт нүүж ирсэн бөгөөд ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс хуулийн дагуу сумын иргэдэд давуу эрхтэйгээр газар олгосон эсэхэд эргэлзэж байсан. Харин тэдний нийтлэг бодол нь гадны хүмүүс газрыг их том хэмжээтэйгээр авсан гэж үздэг. Ихэвчлэн чинээлэг гадаадууд болон гадны хүмүүст эгдүүцэж байгаа яриаг бид сонсож байсан. Хүмүүс зарим газраа түрээслүүлж эсхүл худалддаг. Зарим хүмүүс газраа ашиглахгүй, гэхдээ хүн оруулахгүй хашаалаад явсан байдаг. Бусад олон орны байдалтай адилаар хашаажуулалт ихэсч, зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хүмүүс газрын (өсч буй) үнэ цэнийг мэдэрсэнтэй холбоотой. Гэвч, зарим тохиолдолд орон нутгийн хүмүүсийн эрхтэй, ашиглахгүй байгаа газрыг гадныхан ашиглах болж, түрээслэх, зээлээр өгөх зэрэг хувийн зохицуулалтуудыг хийх болсон байна. Сумын захиргааны ажилтнуудын мэдээлснээр 2003 оноос газрын гэрчилгээжүүлэлтийн ажил эхэлж байх үед олон хүмүүс гар аргаар уул уурхай эрхэлж, бэлэн мөнгөтэй болоход дэндүү анхаарч, газартай байхын ач холбогдлыг ойлгодоггүй байсан. Харин тэд сүүлд нь гадныхан ирж газар ашиглаж, үр шимийг нь хүртэж байгааг анзаараад газар авах хүсэлт их гаргах болсон гэсэн юм.

Дээрх бүх үл итгэлцэх байдлаас гадна бидний олж мэдсэнээр том хэмжээний газрыг гадаадын хүмүүс болон гадны хүмүүс хэрхэн олж авдаг тухай мэдээлэл хомс байсан. Хүмүүс газар хашаалсны дараа л мэдэж, гайхдаг байна. Суурь судалгааны бүх эмэгтэй хариулагчдын (68 хүний 41) 47% нь бүх эрэгтэй хариулагчдын 50% (54 хүний 27 нь) дараах мэдэгдэлтэй санал нийлсэн “Манай нутагт компаниуд ирж энгийн иргэдтэй хэлэлцэлгүйгээр газар авч чаддаг”. Төмрийн үйлдвэр барихад зориулж олгосон газрын тухай хүмүүс их дурьдсан. Энэ үйлдвэрийн ажиллагаа хортой учир малчид гомдол саналаа илэрхийлж хаалгуулсан гэсэн. Гэхдээ хүмүүс тэд дахин үйл ажиллагаа эхлэхий дээ хэмээн санаа зовниж байлаа.

Бэлчээрийн талхагдал, усны хомсдол

Уул уурхай, өсөн нэмэгдэж буй фермийн аж ахуй, мөн сумын малын тоо нэмэгдэж байгаа, гадны хүмүүс малтайгаа их ирэх болсон нь Борнуурын усны нөөц муудаж, бэлчээр талхагдахад хүрч байгаа гэж хүмүүс үздэг байна. Гадны хүмүүс сумын бэлчээрийг ашиглахын тулд сумын засаг даргад оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргах хэрэгтэй байдаг. Гэхдээ ЗБУ, ХХЯ-ны оролцогчдын хэлснээр Жаргалант, Зүүнхараа сумдын малчид орон нутгийн татвар төлөлгүйгээр зуны бэлчээрийг нь ашигладаг байна. Зуны бэлчээр их сүйдсэн бөгөөд хүмүүс даац хэтэрсэн гэж үздэг. Усны нөөц мөн багасч байгаа учир уламжлалт малчдын хувьд анхаарал татсан сэдэв болж байна. Энэ нь мөн үндэсний хэмжээний нөхцөл байдал юм.

Баруун аймгуудаас шилжин ирэгсэд эхлээд малгүй ирдэг, тэд дараа нь оршин суух зөвшөөрөл аваад их хэмжээний малаа авчирдаг учир нутгийн хүмүүс дургүй байдаг туйха бидэнд хэлсэн. Гэхдээ Нарт багын тэдний ихэнх нь хамаатан садныхаа хажууд амьдардаг, газар олж авч чадаагүй, хэзээ мөдгүй хөөгдөх байх гэсэн сэтгэгдлээр амьдарч байгаа нь тэднийг Борнуурын

эмзэг бүлэгт оруулахад хүргэж байна. Тэд Борнуурт Улаанбаатарын компаниуд ирж сүү худалдаж авдаг учир эхлээд хамаатныдаа ирж, дараа нь газар олж авах сонирхлоор ирдэг. Гэхдээ газар авахад хэцүү болсон учир хамаатныдаа амьдарсаар байдаг байна.

ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс уул уурхайгаас шалтгаалан усны чанар буурч байгаагаас гадна том хэмжээний газар авсан хүмүүс худаг их гаргадаг хэмээн гомдоллосон. Мөн жуулчны компаниуд хаягдал их гаргаж, Борнуурын голын усыг бохирдуулж, усны чанарыг муутгаж, малд аюул занал учруулж байгаа тухай ярьсан.

Суурь судалгааны мэдээллээр нутгийн байгаль орчин доройтож байна гэж үзсэн хүмүүсийн тухай мэдээллийг 9- р хүснэгтэд харуулав. Эмэгтэй хариулагчдын 80% (88 аас 70 нь), эрэгтэй хариулагчдын 85% (54 өөс 46 нь) нь Борнуурын байгалийн нөөц, байгаль орчны доройтлын асуудлууд байгаа гэсэн ба эмэгтэй хариулагчдын 63% (55), эрэгтэй хариулагчдын 54% (29) нь усны бохирдолд санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.

**Хүснэгт 9. Борнуур сум, Нутгийн байгаль орчин доройтсон гэж үзэж байгаа хариулагчдын
 жендерийн байдал**

	Тийм (жендерээр ялгасан хувь)		Үгүй (жендерээр ялгасан хувь)		Мэдэхгүй (жендерээр ялгасан хувь)	
	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр
Танай нутагт байгалийн нөөцийн доройтлын асуудлууд байгаа.	80	85	15	9	6	6
Танай нутагт усны бохирдлын асуудлууд байгаа.	63	54	32	43	6	4
Танай нутагт усны нөөцийг олж авахтай холбоотой асуудлууд байгаа.	52	57	40	39	8	4
Танай нутагт ойн нөөцөөс хүртэхтэй холбоотой асуудлууд байгаа.	39	50	23	28	39	22

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, Зориудаар нэмж авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд ба санамсаргүй түүврийн өрхүүдийн мэдээлэл багтсан. Эмэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 88. Эрэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 54.

Ой

Борнуур суманд хяналтгүй, хууль бус огтлол их явагдсаны улмаас ойн нөөц хурдацтай багасч байгаад манай ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс санаа зовниж байсан. Суурь судалгааны эмэгтэй хариулагчдын 39% (88 аас 34 нь), эрэгтэй хариулагчдын 50% (54 өөс 27 нь) нь ойн нөөцийн хомсдол сумын гол асуудал гэж илэрхийлсэн. Гэхдээ ихэнх хүмүүс ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд таатай ханддаг бөгөөд тэдний зарим үйл ажиллагаа эерэг хувь нэмэр оруулдаг бололтой байсан.

Ойн тухай хууль 2012 онд өөрчлөгдсөнөөс хойш ойгоо хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх зорилгоор ойн нөхөрлөл (ОН) байгуулж ойг эзэмшиж, хамгаалах гэрээг сумын засаг даргатай хийж болно. 2016 оны байдлаар Нарт, Бичигт багт нийт 10 ойн нөхөрлөл (214 гишүүнтэй) сумын 36,000 га ойн 22,000 га –г нь менежментдээ авсан байна. Эдгээр 10 ОН-ийн 40% нь эмэгтэй гишүүд, ихэнхдээ эхнэр нөхөр хоёул нөхөрлөлийн гишүүн байдаг, ихэнх ОН-ийн дарга нар эрэгтэй хүн байдаг. Нөхөрлөлийн бүх гишүүд нутгийн харьяалалтай байх ёстой бөгөөд тэдний 50% нь ойнхоо ойролцоо амьдардаг байх ёстой. Гэхдээ үүнийг Борнуурын хувьд нарийн тогтоогоогүй бөгөөд ОН-ийн олон гишүүд сумын төвийн Өгөөмөр багаас ирсэн байдаг бололтой. Сумын төвийн иргэд хөдөө амьдарч буй малчидтай харьцуулахад боломжийн амьдралтайд тооцогддог байна. Манай ЗБУ, ХХЯ-д оролцсон зарим ОН-ийн гишүүн бус хүмүүс ОН байгуулах тухай мэдээллийг бүх хүнтэй солилцоогүй, ОН-ийн хүмүүс сумын захиргаатай ойр дотно байдаг хүмүүс бөгөөд тэд жинхэнэ ашиг тусыг нь хүртсэн, сумын хэмжээнд ОН-ийн гишүүнчлэлийг илүү өргөн хүрээтэйгээр байлгах хэрэгтэй, хууль бус мод огтлол бүрэн зогсоогүй байх гэх мэтээр эргэлзэж байсан.

2016 оны судалгааны ажлын байдлаар ямар нэгэн хувь хүн ОН-ийн эзэмшлийн ойгоос мод бэлтгэх (ОН-ийн гишүүн байсан ялгаагүй) бол Сумын байгаль орчны байцаагчаас зөвшөөрөл авах ёстой. Нэг машин түлээний мод авахад 9,000 (4 ам.доллар) төгрөг, нэг машин орон сууц барих мод авахад 30,000 (14 ам.доллар) төгрөг байсан ба харин ОН-ийн гишүүдэд хямдралтай. Ойн хол байдаг, хүнд хэцүү хөдөлмөр учир ихэвчлэн эрэгтэй хүмүүс түлээний мод бэлтгэх мод авах ажил хийдэг. Мөн бидэнд өрх толгойлсон эмэгтэйтэй өрхөд хөнгөлөлт үзүүлдэг байсан одоо үгүй болсон гэж хэлсэн. ОН-ийн гишүүдийн хүмүүсийн зөвшөөрлийг шалгаж, тэднийг хууль бус огтлол хийхгүй байхад хяналт тавих ёстой.

ОН-үүд мөн ойн түймрээс сэргийлэх, ойг цэвэрлэх ажил хийх ёстой. Жишээ нь унасан модыг авч, мод тарих, ойн арчилгааны огтлол хийх ёстой. Борнуур суманд хоёр нөхөрлөөл зөгий үржүүлж, балыг нь худалдаалдаг. Бусад нь жимс түүж, жимсний чанамал хийдэг. Ерөнхийдөө ОН-үүд ойн дагалдах баялгыг хүртэж ашиглах боломжтойг ойлгосон. Учир нь тэд ойгоо хамгаалахын тулд өөрсдийн хөрөнгөө зарцуулдаг бөгөөд модноос ашиг олдоггүй байна. ОН-ийн гишүүд малчидтай зөрчилтэй байдаг нь ажиглагдсан. Тэд ойд орж малаа бэлчээрлүүлж, мал нь жижиг мод бут идчихдэг хэмээсэн. Ингээд зарим ОН-үүд ойгоо хашаалсан бөгөөд бусад нь бас хашаалах бодолтой байгаа. Энэ нь бэлчээргүй болох нутгийн малчдын дургүйцлийг хүргэж байна.

Газар олгох үйл явц

Бидний ЗБУ, ХХЯ-аас харахад албан ёсны газар олгох процесст шийдэгдээгүй асуудлууд байгаа бололтой. Олон оролцогч газрын гэрчилгээгээ авахын тулд олон дахин өргөдөл гаргадаг, хүнд сурталтай, нээлттэй биш гэж илэрхийлсэн. Янз бүрийн төрийн ажилтнууд руу явуулдаг тэд нар нь дахин дахин өөр бичиг баримт шаарддаг гэсэн байна. Дээр өгүүлсэнчлэн, ихэвчлэн эмэгтэйчүүд энэ их цаг зарцуулсан өргөдөл гаргах ажлыг хийдэг ч зөвхөн эрэгтэй хүний нэр дээр гэрчилгээ гардаг. ЗБУ, ХХЯ-ны ихэнх оролцогч энэ нь эмэгтэйчүүд илүү тэвчээртэй, хүлээцтэй учир энэ ажлыг хийх ёстой хэмээн үзэж гэхдээ эрэгтэйчүүд өрхийн тэргүүн учир тэдний нэрээр гэрчилгээ гаргах нь зүйтэй хэмээсэн байна. Гэхдээ нэгэн зөвхөн эмэгтэйчүүд оролцогч ЗБУ-ын үеэр эрчүүд бас энэ хугацаа зарцуулдаг гэрчилгээ авах, банкны зээл хөөцөлдөх ажилд оролцох хэрэгтэй гэж үзсэн байна. Нэгэн эмэгтэй нэг удаа нөхөр нь хамт явсан үед ажил их амжилттай бүтсэн хэмээсэн.

Ихэнх хүмүүс холбогдох хуулиудын талаар мэдлэг сайтай байгааг 10-р хүснэгтээс харж болно. Жишээ нь, бүх эмэгтэй хариулагчдын 83% (88-аас 73 нь), бүх эрэгтэй хариулагчдын 89% (54 өс 48) нь эмэгтэй хүн газар өмчлөх эрхтэй гэдгийг мэдэж байсан. Бүх эмэгтэй хариулагчдын 99% (79 нь), бүх эрэгтэй хариулагчдын 94% (51) нь газар өмчлөлийн асуудал дээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах нь хууль бус асуудал мөн гэж үзсэн. Гэхдээ бүх эмэгтэй хариулагчдын 51% (45), бүх эрэгтэй хариулагчдын 39% (21) нь “тухайн газрын эрхтэй байх нь түүний доор байгаа ашигт малтмалын бас эрхтэй гэсэн үг” гэсэн буруу ойлголттой байна. Мөн бүх хариулагчдын 26% (нийт 142-ийн 47) нь энэ тухай мэдэхгүй байсан. Бүх эмэгтэй хариулагчдын 38% (33), бүх эрэгтэй хариулагчдын 26% (14) нь Монгол улсын хуулиар эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс газрын дауу эрхтэй гэж боддог байна. Үүнийг хуулийн зарим зүйл заалтуудад “өрхийн хэрэглээний” гэсэн нэр томъёо орсон байдаг учир хүмүүс өрхийн тэргүүнийхээ нэр дээр бүртгүүлэх хандлагатай байдагтай холбон үзэж болно. Мөн 10-р хүснэгтэд бүх эрэгтэй хариулагчдын 33% (18) нь, бүх эмэгтэй хариулагчдын 27% (24) Борнуурт байгалийн нөөцийн талаар шийдвэр гаргахад эмэгтэйчүүд чухал үүрэгтэй оролцдог гэж үзсэн байна. Бүх эрэгтэй хариулагчдын 52% (28) нь, бүх эмэгтэй хариулагчдын 32% (28) нь нутгийн газрын менежментийн талаарх шийдвэр гаргахад бүх хүмүүстэй зөвлөлдөж, хамруулдаг гэсэн байна.

Хүснэгт 10. Борнуур сум, Монгол улсын газрын тухай хуулийн талаарх мэдлэг -жендерийн ангиллаар харуулав.

	Тийм (жендерээр ялгасан хувь)		Үгүй (жендерээр ялгасан хувь)		Мэдэхгүй (жендерээр ялгасан хувь)	
	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр
Танай орны хуулиар эмэгтэйчүүдийг газар өмчлөхийг зөвшөөрдөггүй.	5	4	83	89	13	7
Танай орны хуулинд эрэгтэйчүүдийн газрын эрх эмэгтэйчүүдийнхээс илүү давуу байдаг ба эхнэрүүдийн газрын эрхээс нөхрүүдийн газрын эрх илүү давуу байдаг.	38	26	53	65	9	9
Танай оронд газар өмчлөлийн тухайд эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдэд ялгавартай хандах нь хууль бүс үйлдэл мөн.	94	90	6	6	5	0
Танай орны хувьд, хэрэв та газрын эрхтэй бол газрын дээр эсхүл доор нь байгаа ашигт малтмалын бас эрхтэй гэсэн үг.	51	39	24	33	25	28
Нутгийн газар зохион байгуулалт/ менежментийг хийхэд танай нутгийн бүх хүмүүс оролцож, зөвлөлддөг.	32	52	50	44	18	4
Танай нутагт эмэгтэйчүүд байгалийн нөөцийн талаар шийдвэр гаргахад томоохон үүрэгтэй оролцдог.	27	33	48	46	20	25

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, Зориудаар нэмж авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд ба санамсаргүй түүврийн өрхүүдийн мэдээлэл багтсан. Эмэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 88. Эрэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 54.

ЗБУ, ХХЯ-ны үүлзалтаар газар авахад ядуу хүн, шинээр нүүж ирсэн хүний аль альныг нь ялгаварлан гадуурхдаг (шинээр ирсэн ядуу хүмүүс бас багтана) гэж мэдэгдсэн. Ихэнх хүмүүс газрын бүртгэл, гэрчилгээ авахад харин жендерийн хувьд ялгавартай ханддаг гэдэгт итгэдэггүй.

Ихэнх хүмүүс хэрэв хүмүүс өөрсдөө хүсвэл эрэгтэй, эмэгтэй аль нь ялгаагүй ба бэлэвсэн болон салсан хүмүүсийн хувьд ч газрынхаа гэрчилгээг эмэгтэгийн нэр дээр болгох амархан эсхүл хэцүү гэсэн хариулт өгч байсан.

Гэхдээ салалтын үед (Борнуурын хувьд нийтлэг зүйл биш байсан тухай дээр дурьдсан) асуудлыг шүүх дээр шийдэх магадлалтай. Ийм тохиолдолд гэрчилгээн дээр нэр нь байгаа хүн дээр асуудал эерэгээр эргэх магадлалтай (хэрэв зөвхөн нөхрийн нэр гэрчилгээн дээр байвал нөхөр нь ялна гэсэн үг). Гэхдээ ЗБУ, ХХЯ-н оролцогчид тэд хэзээ ч салах тухай бодож байгаагүй, өрхийн хэрэглэж буй газрыг хэрхэх тухай ч хэзээ ч бодож байгаагүй гэж хэлсэн. Тэд мөн салалтыг шийдвэрлэсэн шүүхийн нэг ч хэргийг мэдэхгүй байсан бөгөөд ямар байх талаар мэдэхгүй байлаа. Харин сумын газрын хүрэлцээ муу болж байгаа учир гэрээ орхиж явсан хүн дахин шинэ хашааны газар авахад хэцүү байх гэж үзсэн. Иймд гэр бүлийн хүчирхийллийн үед салалгүй зохицож амьдрахаар шийддэг байж болзошгүй.

Манай ЗБУ, ХХЯ-ны үеэр өрх толгойлсон эмэгтэйчүүд тэдэнд их ачаалалтай байдаг учир сумын газар олгох процесст жендерээс шалтгаалан алагчилдаг тухай илүү мэдэж байсан.

Мөн бид уламжлалын дагуу мал маллах нь эрэгтэй хүний ажил учир өрх толгойлсон эмэгтэйтэй өрхөд бэлчээр, хадлангийн газар олоход хэцүү байдаг тухай, бэлэвсэн эмэгтэйн эрхийг хүндэтгэдэггүй тухай олж мэдсэн.

Орон сууцны газар

Дээр өгүүлсэнчлэн газрын төвлөрөл, газрын хомсдолын улмаас олон хүмүүс хуулийн дагуу хашааны 0.07 га газрынхаа гэрчилгээг авч албан ёсны болгох ажлыг эхлүүлсэн. 2016 оны 11-р сард газрын даамлын хэлснээр сумын насанд хүрсэн нийт иргэдийн 47% нь хашааны газрын өмчлөх гэрчилгээгээ авсны 54.5% нь эмэгтэйчүүд юм. Гэхдээ дээр өгүүлсэнчлэн, ЗБУ, ХХЯ-аар илэрхий болсны дагуу өрхүүд гэрчилгээгээ ихэвчлэн өрхийн тэргүүнийхээ нэр дээр авдаг. Эхлээд амьдарч байгаа хашаа байшингийнхаа гэрчилгээг өрхийн тэргүүн нөхрийнхөө нэр дээр аваад дараа нь хоёр дахь хашаа байшингаа эхнэрийн нэр дээр авах нь элбэг байгаа харагдсан. Учир нь хуулиар Монгол улсын иргэн бүр орон сууцны газар авч болно гэж заасан байгаа.

Зарим өрхүүд анхны хашаа байшингийнхаа газрын гэрчилгээн дээр эхнэр нөхөр хоёр хоёул нэрээ оруулсан нь буруу тактик байсан гэж үзсэн. Дараа нь хуулийн дагуу эхнэр нь газар авч чадахгүй байдалд хүрч байгаа учир. Нөгөө талаар, ЗБУ-ын оролцогчид суманд олгох газар үлдээгүй учир эмэгтэйчүүд газар өмчлө аргагүйд хүрч байгаа талаар санаа зовнин илэрхийлсэн. Ядаж л тэд дуртай газраа авч чадахгүйд хүрч байгаа. Энэ нь магадгүй одоо байгаа газрынхаа гэрчилгээн дээр нэрээ оруулах нь урт хугацаанд тэдний газар эдэлбэрийн эрхийг баталгаажих ганц арга нь байж болно.

Санамсаргүй түүврийн өрхийн 77% (86) нь нэг болон түүнээс дээш орон сууцны газар өмчилдөг гэж мэдэгдсэн. Гэхдээ энэ газар нь зөвхөн Борнуурт байдаггүй байж болно.

69 өрх нэг хашааны газартай, 17 өрх 2 хашааны газартай, нийт 111 өрхийн 103 нь хашааны газартай гэсэн үг. 11-р хүснэгтэд үзүүлэв.


Хүснэгт 11. Борнуур сум, Санамсаргүй түүврийн өрхийн орон сууцны газрын өмчлөл/эзэмшлийн байдал

	Хашааны газаргүй өрхийн тоо	1 газартай өрхийн тоо	2 газартай өрхийн тоо	Хариулаагүй	Санамсаргүй түүврийн 111 өрхийн өмчилж буй хашааны газрын тоо
Өрхийн тоо	24	69	17	1	103

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Түүврийн хэмжээ N = 111.

Санамсаргүй түүврийн өрхийн жаран есөн хувь (77) нь өрхийнхөө үндсэн буюу өрхийн гишүүд ихэвчлэн амьдардаг орон сууцны газар эсхүл хашаа, хорооны (өвөлжөө) газрыг өмчилж эсхүл эзэмшиж авсан. 29% (32 өрх) нь түрээс төлөхгүйгээр бусдын хашаа, хороо, орон сууцны газар дээр зээлээр амьдарч байгаа. Хоёр өрх хариулт өгөөгүй байна. Мандал багын хувьд өмчлөх, эзэмших эрхээ авсан байдал нь түгээмэл, харин Нартад бага байв. 13- р зураглалд өрхийн тэргүүний жендерийн хувьд ялгаа бараг байхгүй нь харагдаж байна.

Зураглал 13. Борнуур сум, Судалгаанд оролцсон бүх өрхийн үндсэн орон сууцны газрын эдэлбэр



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

111 санамсаргүй түүврийн өрхийн 82 % (91 өрх) орон сууцны үндсэн газрын хувьд хашаа юмуу хороо нь ганц хүний эзэмшил, өмчлөл байхад 17% нь (19 өрх) хамтын өмчлөл, эзэмшил гэж хариулсан байна. Нэг өрх хариулаагүй. Бидний суурь судалгааны зарим өрхүүдийн амьдарч буй үндсэн сууцны газар нь өрхийн тэргүүн эрэгтэй, эмэгтэйн нэг хүний нэр дээр биш харин ажил олгогч, хамаатан эсхүл найзынх нь нэр дээр байсан.

Тэргүүн нь эрэгтэй таван өрхийн үндсэн орон сууц нь эхнэрийн нэр дээр бүртгэлтэй байсан. Энэ нь бидний ЗБУ, ХХЯ-гийн үеэр айлууд газрын янз бүрийн гэрчилгээтэй, амьдралын янз бүрийн

зохицуулалттай байдаг, хэрэв тэд хэд хэдэн газартай бол эхнэр нөхөр хоёрын нэр дээр тус тусад (нэг хүний өмч) нь гэрчилгээ авдаг гэсэн үр дүнтэй таарч байна.

Өгөөмөр багын өрхүүд үндсэн сууцны газрын хамтын өмчлөл хамгийн өндөр байсан (жишээ нь гэрчилгээ нь нэгээс дээш хүний нэр дээр байх). Санамсаргүй түүврийн өрхийн 21% нь (33 өрхийн 7 нь) ингэж мэдэгдсэн. Энэ багт жендерийн ялгаа хамгийн их харагдсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 35%, тэргүүн нь эрэгтэй өрхийн 19% нь хамтын өмчлөлийн гэрчилгээтэй. 12-р хүснэгтэд харуулав. Бидний мэдсэнээр Өгөөмөр багын энэхүү онцгой нөхцөл байдлыг хоёр хүчин зүйлээс шалтгаалж байна. Эхнийх нь сумын төвийн хүмүүс хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл арай илүү учир уламжлалт ёс заншилд үндэслэн шийдвэр гаргах нь бага учир эхнэр нөхөр хоёрын аль альных нь нэр дээр гэрчилгээгээ гаргуулдаг байх. Хоёрдугаарт, манай ЗБУ, ХХЯ –ын оролцогчид өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд ихэвчлэн хүүхдийнхээ нэрийг ялангуяа эрэгтэй хүүхдийнхээ нэрийг гэрчилгээн дээр оруулдаг гэж тайлбарласан учир хамтын өмчлөлийн гэрчилгээ бүр зөвхөн эхнэр, нөхрийнх биш юм. Хосуудын аль нэг нь нас барахад бэлэвсэрсэн хүний нэр дээр ихэвчлэн газрыг өвлүүлдэг ч Иргэний хуульд зааснаар бэлэвсэрсэн болон түүний үр хүүхдүүдэд хамтран өвлүүлэх, тэр ч байтугай зарим тохиолдолд хүүхдүүдэд нь өвлүүлэх явдал гардаг байна.

Хүснэгт 12. Борнуур сум, Судалгаанд оролцсон бүх өрхийн үндсэн сууцны өмчлөлийн байдал

	Хамтын өмчлөлтэй сууцны газар		Нэг хүний өмчлөлийн сууцны газар	
	Багын бүх өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн эзлэх хувь	Багын тэргүүн нь эрэгтэй бүх өрхийн эзлэх хувь	Багын бүх өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн эзлэх хувь	Багын тэргүүн нь эрэгтэй бүх өрхийн эзлэх хувь
Бичигт	11	19	89	81
Мандал	10	18	90	82
Нарт	13	9	88	91
Өгөөмөр	35	19	65	81

Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Үүнд зориудаар нэмж судалгаа авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, санамсаргүй түүврийн өрх бүгд багтсан. Бичигт багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 19. Бичигт багын тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 16. Мандал багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 10. Мандал багын тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 22. Нарт багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 8. Нарт багын тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 22. Өгөөмөр багын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 23. Өгөөмөр багын тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 21. Нэг тэргүүн нь эрэгтэй өрх хариулаагүй.

Санамсаргүй түүврийн өрхийн наян гурав нь газрынхаа заримд нь бичиг баримт авсан. Нийтдээ 177 бичиг баримт байсан бөгөөд 13-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 13. Борнуур сум, Санамсаргүй түүврийн өрхийн 111 өрхийн газрын бичиг баримтын төрөл

Бичиг баримтын төрөл	Орон сууц	Хадлан	Байшин	Хаваржаа	Хүнсний ногоо тариалангийн талбай	Хүнсний ногоо	Өвөлжөө	Нийт бичиг баримт
Өмчлөлийн гэрчилгээ	-	-	73	-	-	-	-	73
Эзэмших гэрчилгээ	-	1	7	1	1	59	16	85
Худалдан авсан баримт бичиг	1	-	-	-	-	-	-	1
Эрхийн гэрчилгээ	-	1	-	-	-	-	-	1
Ашиглах гэрчилгээ	-	6	-	-	-	-	-	6
Ашиглах эрхтэй гэрчилгээ	-	6	-	-	-	-	-	6
Ашиглах эрхийн зөвшөөрөл	-	5	-	-	-	-	-	5
Нийт бичиг баримтын тоо	1	19	80	1	1	59	16	177

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016.

13-р хүснэгтэд үзүүлсэн бичиг баримтын төрлүүдийг суурь судалгааны оролцогчид бидэнд хэлсэн. Орон сууцны газрын өмчлөх гэрчилгээ, хүнсний ногооны газрын эзэмших гэрчилгээ, өвөлжөөны гэрчилгээ хамгийн нийтлэг бичиг баримт байсан. Энэ хүснэгтэд хадлангийн талбайн олон төрлийн бичиг баримтыг харуулж байгаа. Энэ нь сумын кадастрийн зураглалд орсон ч албан ёсоор гэрчилгээжүүлээгүй (бэлчээрийн газар учир) газар юм. Энэхүү бичиг баримтын төрөлд татварын баримт, кадастрийн зураглал, ашиглах гэрээ, зарим нь бүүр хуульд заагаагүй эзэмших гэрчилгээ гэх мэт байна. Зарим баримт хүчингүй болсон байсан.

ЗБУ, ХХЯ-ын олон оролцогчид сумын захиргаанаас зөвшөөрөл олгосон кадастрийн зураглал хийдэг компани өрсөлдөгчгүй дангаар ажилладаг гэж үзэж, зураглал хийлгэх ажил зардал ихтэй байдаг тухай гомдол мэдүүлж байсан. Энэ компанийн үнэ 10, 000 төгрөгнөөс (5 ам.доллар) 40,000 төгрөг (18 ам.доллар) болтлоо өссөн. Хэрэв иргэд өөр компаниар зургаа хийлгэвэл хүчингүйд тооцдог бөгөөд гэрчилгээ гаргах асуудал дахин хойшилдог гэсэн юм. Дээр өгүүлсэнчлэн ерөнхийдөө ядуу хүмүүсийн хэрэгцээг анхаарч үздэггүй, тэдний өргөдлийг боловсруулах хугацаа хурдан биш байдаг. Гэхдээ нутгийн зариргаанд өргөдлийн асуудлыг зөв шийдэхэд хугацаа хэрэгтэй байдаг олон асуудлууд байдаг. Ялангуяа, сумын төвд нэг газар дээр олон хүн нэхэмжлэл гаргах гэх мэтээр кадастрийн зураглал давхцах зэрэг асуудлууд байдаг байна. Түүнчлэн, сумын газрын даамлын хэлснээр, урьд нь ажиллаж байсан кадастрийн зураг хийдэг компани ашиггүй байсан учир хийхээ больсон учир хүмүүс аймгийн зөвшөөрөлгүй өөр компаниар хийлгэх болсон. Харин газрын гэрчилгээг тогтсон, шударга замаар авахын тулд кадастрийн зургийг стандартын дагуу хийж, батлуулах ёстой байдаг гэсэн юм.

Хүнсний ногоо, тэжээлийн тариалангийн газар

Суурь судалгааны санамсаргүй түүврийн өрхийн 70% (78) нь Борнуурт өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэйгээр оршин суух бус газартай гэсэн байсан. Ийм газрын 55% нь тухайн өрхийн харьяа багт байдаг ба үлдэгдэл 45% нь сумын өөр багт байдаг байна. Тиймд бидний суурь судалгаанд оролцсон хүмүүс Монгол орны өөр нутагт суурьшлын зорилгогүй газар аваагүй болох нь харагдсан. Борнуурын суурьшлын зорилгоор бус газар эзэмшдэг өрхүүдийн 95% нь (78 аас 74 нь) газраа төрийн байгууллагад хандаж авсан, хоёр өрх худалдан авсан, бас нэгэн хоёр айл газраа хэрхэн олж авсан нь тодорхойгүй байсан.

Суурьшлын газраас гадна Борнуурын иргэд сумын захиргаанаас өрхийн хэрэглээнд зориулж тариалан эрхлэх 5 хүртэлх га газрыг хүсч болно. Ийм газар нь 60 жилийн эзэмшлийн эрхтэй (үрт хугацааны түрээс), мөн худалдаа арилжаа явуулах зорилгоор 100 га хүртэлх газрыг ашиглах эрхтэйгээр (богино хугацааны түрээс) авч болох юм. 2016 оны ажлын үед байгалийн усалгаатай 1 га газрын жилийн төлбөр 1,000 төгрөг (46 ам.цент), харин усалгаат талбайн 1 га газрын төлбөр 2,000 (92 ам.цент) төгрөг байв. Энэ тариалан эрхлэх газрыг компаниуд тендерийн зарчимаар арилжааны зорилгоор авч болдог бол өрх айллууд зөвхөн хүсэлт гаргах ёстой.

Орон сууцны газар, хүнсний ногоо, тэжээлийн тариалангийн газрыг ихэвчлэн (эрэгтэй) өрхийн тэргүүний нэр дээр өгдөг. Мөн ЗБУ, ХХЯ-ын эмэгтэй эрэгтэй ихэнх хүмүүс үүнийг асуудал гэж үзээгүй. Эдгээр газраас олсон ашиг шимийш өрхөөрөө хүртдэг. Харин гэр бүлийн салалт, бэлэвсрэлт болох үед эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн баталгаат байдал алдагдах эрсдэлтэй. Дээр өгүүлсэнчлэн, арилжааны зорилгоор тариалан эрхлэх асуудал ихэвчлэн эрэгтэй хүний ажил байдаг учир.


ЗБУ, ХХЯ-ын олон оролцогчид гадны хүмүүс, компаниуд төрөөс зарласан газрын дуудлага худалдаанд оролцох чадавхи, нөөцтэй тул том хэмжээний газрыг авдаг гэж үздэг. Харин амьдрал дээр тариалан эрхлэх 2 га газар авахад ч нутгийн иргэдэд хэцүү байдаг байна. Санамсаргүй түүврийн 78 өрхийн 56 - гийн суурьшлын бус газар нь өрхийн тэжээл, хүнсний ногоо тарьсан тариалангийн газар байна. Үлдсэн 22 айл нь судалгаа авч байх үед өөрсдийн тариалангийн талбай дээрээ ногоо тариалаагүй байсан. Дээрх 22 өрхийн суурьшлын бус газрын нийт хэмжээ нь 214 га байсан ба энэ нь 182 га –д тариалалт хийсэн 56 өрхийн газрын

хэмжээнээс их байна. 2002 оны газрын хуулийн дагуу, газрыг үр ашигтай ашиглах зорилгоор орон нутгийн захиргаанаас хэрэв өрх ногооны талбайгаа (өрхийн хэрэглээний эзэмшлийн гэрчилгээтэй) хоёроос гурван жил ашиглаагүй бол захиргаанаас энэ газрыг дахин хуваарилах талаар журам гаргасан. Гэсэн хэдий ч усалгаатай талбай дээр томоохон газартай олон хүмүүс газар дээрээ ногоо тарилгүй өнжөөж эсхүл бусдад түрээсэлдэг тухай олон хүмүүс ярьсан юм. Нэг га –г жилд 150,000 төгрөгөөр (69 ам.доллар) түрээслүүлдэг байна. Мөн бид жижиг газрын эзэд ногооны газраа ашиглахгүй бусдад түрээслүүлж эсхүл хамаатнуудаа түр өгдөг тухай мэдсэн. Олон ядуу өрхүүд, гар аргаар алт олборлож байгаа хүмүүс ногоон талбай авч мөнгөн орлого олж, амьдралаа сайжруулах найдлага тавьдаг. Гэхдээ социализмын үеийн усалгаат тариалангийн талбайг иргэдэд олгож дууссан, сумын өөр газар тэжээл тарих юмуу хүнсний ногоо тарих газар авах үйл явц орон сууцны газар авахтай адил хэцүү, хугацаа их зарцуулдаг.

Газрын маргаан

Суурь судалгаанын бүх өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 18 % (60 аас 11 нь) нь сүүлийн 12 сарын хугацаанд газар эсхүл хөрөнгөтэй холбоотой маргаанд оролцож байсан гэж мэдэгдсэн. Харин бүх тэргүүн нь эрэгтэй өрхийн зөвхөн 11 % (82 оос 9) нь тийм байсан. Нийтдээ санамсаргүй түүврийн 111 өрхийн 13 нь газрын маргаанд оролцож байсан ба 14-р зураглалд маргааны төрлийг харуулав.

Зураглал 14. Борнуур сум, Санамсаргүй түүврийн өрхийн газрын маргааны төрлүүд



Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа 2016. Түүврийн хэмжээ N = 13.

Бидний суурь судалгаагаар бүртгэгдсэн түгээмэл газрын маргаан нь өрхийн суурьшлын газрын гэрчилгээ гаргуулах хүсэлтийг хойшлуулдаг явдал, ногооны талбай, хадлангийн талбайн газар олгох тариалангийн газрыг тойрсон маргаан юм. Зарим маргаан хүчирхийлэл, зодоон цохионд хүрсэн байсан. Мөн зарим маргаан газар олгох үйл явцад алдаа гарснаас газрын хилийг буруу хийх, сумын кадастрийн зураг дээр газар өмчлөлийн мэдээллийг буруу оруулах зэргээр маргаан гаргахад хүргэдэг байна.

Манай ЗБУ, ХХЯ-ын оролцогчид бэлчээрийн газрыг хүнсний ногоо, тэжээл тарихад зориулан их хэмжээгээр олгосноор мал тариалангийн талбайд орж тариаланч, малчдын дунд маргаан их гарахад хүргэдэг байна. Үүнийг 14-р хүснэгтэд тодорхой харуулав. Бүх эмэгтэй хариулагчдын 70% (88 аас 62 нь), бүх эрэгтэй хариулагчдын 76% (54 өөс 41 нь) малчид, тариаланчдын хооронд гарч буй маргаан асуудал болж байгаа, үүрхайчид болон хөрөнгө оруулагчдын хоорондын маргаанаас ч илүү том асуудал болж байгаа юм.

14-р хүснэгтэд газрын болон байгалийн нөөцийн маргааныг шийдвэрлэдэг тал дээр нутгийн иргэдийн шүүх засаглалд итгэх байдлын тухай мэдээллийг агуулж байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бараг тал нь хэрэг шийдүүлэхэд амаргүй байдагтай санал нийлсэн.

Хүснэгт 14. Борнуур сум, Байгалийн нөөцийн маргааны талаарх мэдлэг, гендерээр ангилсан

	Тийм (хариулагчдын гендерийн хувь)		Үгүй (хариулагчдын гендерийн хувь)		Мэдэхгүй (хариулагчдын гендерийн хувь)	
	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр
Танай энд уурхайчид болон нутгийн хүмүүсийн хоорондын маргаан асуудал биш.	24	39	44	43	32	19
Танай энд хөрөнгө оруулагчид, нутгийн хүмүүсийн хоорондын маргаан асуудал биш.	24	44	32	28	44	28
Танай энд газар тариаланчид болон малчдын хоорондын маргаан асуудал биш.	19	20	70	76	10	4
Танай нутагт газар болон байгалийн нөөцийн талаарх маргааныг зөвөөр шийдвэрлүүлэхэд амаргүй.	49	48	24	37	27	15

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, Зориудаар нэмж авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд ба санамсаргүй түүврийн өрхүүдийн мэдээлэл багтсан. Эмэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 88. Эрэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 54

Бэлчээрийн газрын менежмент

Дээр өгүүлсэнчлэн санамсаргүй түүврийн өрхийн 33% нь сүүлийн 12 сарын турш мал аж ахуйгаас хамгийн их орлого олсон байна. Бүх өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 20%, тэргүүн нь эрэгтэй өрхийн 38% нь мал аж ахуйгаас хамгийн их мөнгөн орлого олдог байгаа гендерийн хувьд их ялгаа байгааг харуулж байна. Гэхдээ бүх эмэгтэй хариулагчдын 92% (88 хүний 81 нь), бүх эрэгтэй хариулагчдын 98% (54 хүний 53 нь) “Энэ сумын ихэнх хүмүүсийн амьжиргаа мал аж ахуйгаас хамаардаг” гэсэн мэдэгдэлтэй санал нийлсэн. 15-р хүснэгтэд үзүүлэв. Үүнд ихэнх өрхүүд мал аж ахуйгаас хамгийн их мөнгөн орлого олдоггүй эсхүл ямар ч мөнгөн орлого олдоггүй байсан ч ямар нэгэн малтай байгаа нь харагдаж байна. Мөн мал аж ахуй эрхлэх нь олон хүний хувьд соёлын бахархал бололтой. Үүнийг олонх хүмүүс бэлчээрийн доройтолд санаа зовж байгаагаас харж болно. Бүх эмэгтэй хариулагчдын 64% (88 аас 56), бүх эрэгтэй хариулагчдын 80% (54 хүний 43) “Манай нутагт бэлчээрийн газрын асуудал их байгаа” гэсэн мэдэгдэлтэй санал нэгдсэн. 15-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 15. Борнуур сум, Бэлчээрийн мал аж ахуйн тухай ойлголт, гендерээр ангилсан

	Тийм (хариулагчдын гендерийн хувь)		Үгүй (хариулагчдын гендерийн хувь)		Мэдэхгүй (хариулагчдын гендерийн хувь)	
	М	F	М	F	М	F
Энэ нутгийн хүмүүсийн ихэнхийн амьжиргаа мал аж ахуйгаас хамаардаг	98	92	2	7	0	1
Танай нутагт бэлчээрийн газар тойрсон асуудал их байна	80	64	19	15	2	22

Эх үүсвэр: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, Зориудаар нэмж авсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд ба санамсаргүй түүврийн өрхүүдийн мэдээлэл багтсан. Эмэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 88. Эрэгтэй хариулагчдын түүврийн хэмжээ N = 54.

Өвөлжөө, зуншилгаа, бэлчээрийн газрын хүртээмж

Сумын газрын даамлын өгсөн мэдээллийн дагуу Борнуур сумын бэлчээрийн газрын хэмжээ 69,000 га. Энэ газарт өвөлжөөний бууц барьж зуншилгаандаа гардаг. 2016 оны ажлын үеэр 260 өрх бэлчээртэй залгаа өвөлжөөтэй, ихэвчлэн өрхийн тэргүүний (эрэгтэй) нэр дээр бэртгүүлсэн

эзэмших гэрчилгээтэй байсан. Гэрчилгээ авах үйл явц орон сууцны газар авахтай төстэй эхлээд малчин хүн өөрийнхөө мөнгөөр кадастрийн зураглал хийх шаардлагатай.

Гэхдээ ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс олгох газар байхгүй учир өвөлжөөний газар шинээр авахад маш хэцүү учир залуу гэрлэсэн малчид эцэг эхийнхээ өвөлжөөн дээр амьдархад хүрдэг гэжээ. Мөн ихэнх ахмад хүмүүс өвөлжөөтэй, сумын кадастрийн зураглалд орсон байдаг ч олонх нь эзэмших гэрчилгээ аваагүй байгаа бололтой. Тэд эрхээ албан ёсны бичиг баримтаар баталгаажуулаагүй учир өөр хэн нэгэнд газрыг дахин хуваарилах асуудал үүсэх магадлалтай.

2016 оны ажлын үеэр, хүмүүс өвөлжөөнөөсөө нүүж 5-р сарын 1 нээс 10- сарын 15 хүртэл зуншилгаандаа байх захиргааны журамтай. Урьд нь малчид хаваржаа руу мөн нүүдэг байсан бол одоо өвөлжөө, зуншилгааны хооронд урьдынхаас багахан зайд голдуу нүүдэг болсон байна. Манай ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс хамгийн холдоо одоо бол 40 км, ер нь бол 5 км -ээс ихгүй зайд нүүдэг болсон гэжээ.


Социализмын үед захиргаанаас хүмүүсийг нүүхэд тусалж тээврийн хэрэгслээр хангадаг байсан бол одоо үгүй. Сумын кадастрийн зураглалд зуншилгааны газрын бүртгэдэггүй, эзэмших гэрчилгээ олгоогүй. Харин ихэнх хүмүүс зуншилгаагаа жил бүр нэг газар барьдаг учир тэд зуншилгааны уламжлалт ашиглах эрхтэй гэсэн үг. Ойролцоох өрхүүд бэлчээрээ хамтаар ашигладаг бөгөөд шинээр ирж буй малчид хуучин малчидтай тохиролцох хэрэг гардаг.

Мөн олон малчид малаа бэлчээрт өөрсдөө гаргахаа больсон нэг малд нэг сард 1,000 төгрөг (46 ам.цент) өгч хүнээр маллуулдаг болсон гэж бидэнд хэлсэн. Гэхдээ ихэнхдээ тэд малаа хамаатнууддаа өгч сумандаа эсхүл өөр суманд бэлчээрт гаргадаг гэсэн.

Ерөнхийдөө, малаа хүнд өгч бэлчээрлүүлдэг малчид цөөн тооны малтай байсан. Иймд тэд зардал хэмнэх үүднээс найз нөхөд, хамаатнууддаа малаа өгч бэлчээрт гаргадаг байна. Зарим тохиолдолд тэд малаа харуулж байгаа хүндээ мөнгөн хөлс өгдөг ч ихэнхдээ хүүхдийг нь сумын төвд сургуульд ороход нь гэртээ суулгах, төл малыг нь хашаандаа байлгах гэх мэтээр харилцан тусалдаг байна.

Эдгээр чиг хандлага суурь судалгааны үр дүнгийн 15-р зураглалд харагдаж байна. Бүх өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн 18% (60 өрхөөс 11), тэргүүн нь эрэгтэй бүх өрхийн 36% (82 өрхийн 30) нь малаа өөр хүнээр бэлчээрт гаргуулдаг байна.

Зураглал 15. Борнуур сум, Өрх толгойлсон эмэгтэйтэй өрх (зүүн), тэргүүн нь эрэгтэй өрх (баруун) ийн малаа бэлчээрлүүлж байгаа байдал




Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн суурь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

15-р зураглалд эрчимжсэн мал аж ахуй (бэлчээрт ерөөсөө гаргахгүй) бага хэмжээтэй байгаа нь төрөөс хэдийгээр бодлогоор эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжиж байгаа ч уламжлалт мал аж ахуйтай харьцуулахад бага түвшинд байгаа хэвээр байна. Харин хагас эрчимжсэн мал аж ахуйн хэлбэр илүү түгээмэл байна. 2016 оны ажлын үеэр малчдын нүүдэл багассан, суурьших хандлагатай болсон нь хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, малаа хүнээр бэлчээрлүүлж байгаагийн аль алинтай нь холбоотой байлаа. Мөн энэ нь өрхийн амьдралын хэв маяг, амьжиргаа өөрчлөгдөж байгаатай холбоотой. Урьд өгүүлсэнчлэн өрхийн амьжиргааны эх үүсвэрийн олон янз байдал – албан ажил, газар тариалан, уул уурхай зэрэг байгаа нь малчдын нүүдэл суудлыг зохицуулахад хүндрэл хүргэдэг байна. Мөн хүүхдийнхээ боловсролыг анхаарахын тулд Борнуурын малчин өрхүүд хичээлийн жилд ядаж зарим гишүүдээ сумын төвд амьдруулж зун цаг болоход зуншилгаандаа гардаг байна. Иймд санамсаргүй түүврийн өрхийн 33% ийн наад зах нь нэг гишүүн үндсэн орон сууцандаа байнга амьдардаггүй байна. Энэ нь санамсаргүй түүврийн өрхийн гуравны нэг нь тусдаа хуваагдан амьдарч байна гэж хэлж болно. Нөгөө талаар хагас эрчимжсэн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид өвөлжөөндөө жилийн турш амьдарч малаа хашаандаа байлгаж, өвс тэжээлээр тэжээдэг. Бидний ажиглалтаар зарим өрхүүд нэлээн дэвшилтэт фермтэй зарим нь хашаандаа сүүний цехтэй байсан.

Санамсаргүй түүврийн далан гурван хувь (81) нь юун түрүүнд хэн ч ашиглаж болох нийтийн эзэмшлийн бэлчээр ашигладаг гэжээ. Гэхдээ бас нэг өрх тариаланчийн газрын бэлчээр болгож ашигладаг бөгөөд хуваан эзэмшдэг тусдаа эрхтэй, бас нэгэн өрх сууцны хашааны ойролцоох өөрсдөө давуу эрхтэй газраа ашигладаг байна.

Санамсаргүй түүврийн өрхийн хорин дөрвөн хувь (27 өрх) бэлчээр ашигладаггүй (мөн малгүй) гэж мэдэгдсэн. Дараах 16-р зураглалд тодорхой харуулсанчлан өрх толгойлсон эмэгтэйтэй нийт 60 өрхийн 48% (29) ямар нэгэн мал бэлчээдэггүй, харин тэргүүн нь эрэгтэй нийт 82 өрхийн зөвхөн 17% нь ийм байна. Энэ байдал нь мөн л мал маллахад жендерийн ялгаа их байгааг харуулж байна. Борнуур суманд өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрх цөөн, тэргүүн нь эрэгтэй малчин өрх их байна.

Зураглал 16. Борнуур сум, Судалгаанд оролцсон бүх өрхийн малаа тэжээдэг гол арга хэрэгсэл



Эх сурвалж: ЭГЭЭББ төслийн сурууь судалгаа, 2016. Зураглалд зориудаар сонгосон өрх толгойлсон эмэгтэйчүүд, санамсаргүй түүврийн өрхүүд аль аль нь багтсан. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн түүврийн хэмжээ N = 60. Тэргүүн нь эрэгтэй өрхийн түүврийн хэмжээ N = 82.

Хадлангийн газар

Малчдын хувьд малаа өвөл тэжээхийн тулд хадлан авах нь чухал асуудал. ЗБУ, ХХЯ-д оролцсон хүмүүс хадлан, бэлчээрийн газар нэг газар байсан, бэлчээр ашигладаг хэн ч байсан хадлан

бэлтгэх боломжтой байв. Хүн, малын тоо өссөний улмаас, мөн хүмүүс бэлчээр талхагдаж байна гэж үзэж байгаатай холбоотой хадлангийн талбайн хүрэлцээ муудаж, Борнуурын хадлангийн талбай хувьчлалд орох хандлагатай болсон. Бидэнд хэлэхдээ 2009 оны мал тооллогод үндэслэн, малын тоотой дүйцүүлж сумын засаг дарга өрхүүдэд хадлангийн талбай хуваарилсан гэсэн. Борнуурын малчин өрхийн 80 гаруй хувь нь хадлангийн талбайтай болсон ба хадлангийн нэг га тутамд 800 төгрөгний (37 ам.цент) төлбөр төлөх ёстой. Бэлчээрийг хуулиар хувьчилж болохгүй учир хуваарилсан хадлангийн талбайд ямар нэгэн гэрчилгээ олгогдоогүй байгаа. Гэхдээ газрын даамлын хэлснээр, хадлангийн газартаа кадастрийн зураг хийлгэсэн бол сумын зураглалд бүртгэгдэж, тэдэнд “зөөлөн” эрх олгож байгаа юм гэсэн. 2016 оны бидний ажлын үеэр, зарим өрхийн мал өссөн учир хуваарилагдсан талбайгаа зохицуулах аргагүйд хүргэсэн. Түүнчлэн бэлчээр талхагдсанаас болж хадлангийн гарц муудаж байгаа гэж хүмүүс үзэж байна. Мөн 2009 оноос хойш суманд нүүж ирсэн хүмүүс хадлангийн талбайн хуваарилалтаас хоцорсон, анхны (2009) хадлангийн талбайн хуваарилалт шударга явагдаагүй, харилцаа холбоо сайтай байсан хүмүүс нь том талбай авсан бөгөөд авсан хадлангаа нутгийн ядуу малчдад зардаг гэсэн гомдол байв. Шинээр шилжин ирэгсэд болон залуу малчдад хадлангийн газар олддоггүй учир тэд сумын бусад хүмүүсээс худалдан авдаг байна.

Сумын захиргаанаас 2009 онд хадлангийн талбайтай холбоотой зөрчлийг багасгах оролдлого хийж, малчин өрхүүдэд газар зааж өгсөн ч хадлангийн талбайгаас шалтгаалан олон маргаан гардаг хэвээр, зарим үед зодоон цохион гардаг гэж сонссон. Өрхүүд хоорондоо харилцан ярилцаж маргаанаа шийддэг. Манай ЗБУ-ын эрэгтэй гишүүнгүй өрх толгойлсон эмэгтэйтэй өрх хадлангийн газраа алдах эрсдэлд ордог гэжээ. Учир нь өрх толгойлсон эмэгтэйчүүдийг эрэгтэй малчид ойшоож хэлэлцдэггүй гэсэн. Мөн хадлангийн газрыг хашаалаагүй байдаг нь асуудал дагуулдаг. Зарим хүмүүс өрхийн хадлангийн талбай дээр өөр өрхийн хүмүүс ирж хадлан хийх, эсхүл хадсан бүхлыг нь хулгайлах, зарим нь өвөлжөө барих тохиолдолд ч гардаг гэжээ. Бусад сумаас бөө нар ирж Бичигт багын хадлангийн талбайд бөө мөргөлийн үйлдэл хийснээс болж нутгийн хүмүүс тэр талбайгаас хадлан авахаас айж эмээх зүйл гарсан байна. Манай нэгэн ЗБУ-н оролцогчид Борнуур сумын урд руу, хөрш Батсүмбэр сумын малчидтай хадлангийн газрын маргаан үе үе гардаг гэсэн. Энэ мэтчилэн асуудал их гарч байгаа учир хүмүүс хадлангийн газраа хашаалж эхэлсэн нь сумын нийтийн эзэмшлийн бэлчээрийн газарт улам дарамт үзүүлэхээр байна. Ялангуяа иргэд өөрт олгогдсон газраас их газрыг хашаалах тохиолдолд, ийм зүйл тохиолдож байна.

Өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхүүдэд тулгардаг асуудлууд

Дээр өгүүлсэнчлэн, уламжлалт мал аж ахуй эрэгтэй хүний ажил гэж үздэгтэй холбоотойгоор бэлэвсэрсэн, салсан, тусдаа амьдарч байгаа эсхүл ганц бие эмэгтэйчүүдийн хувьд мал маллахад хэцүү болдог.

Эмэгтэйчүүд малын сааль саах, сүүн бүтээгдэхүүн хийх ажлыг хашаандаа хийдэг байхад мал хариулах, бэлчээрлүүлэх, мал муулах, хадлан тэжээл бэлтгэх зэрэг гадны ажлыг эрэгтэй хүмүүс хийдэг байна. Өвөлжөө, хашаа хороогоо засч сэлбэх, мөн өвлийн 0 –оос доош хэмтэй (-35 хэм) хүйтэнд малаа хариулах ажлыг эрэгтэй хүмүүс хийдэг.

Үүнээс шалтгаалан бэлчээр, хадлангийн газар олж авах асуудлыг эрэгтэй хүмүүс тохиролцож хийдэг ба бэлчээрийн маргаан тэдний дунд гардаг учир өрх толгойлсон эмэгтэйчүүд хэлэхдээ ийм эрэгтэй хүн голлосон орчинд тохиролцоо, хэлцэл хийх хэцүү байдаг гэсэн. Бидний ЗБУ, ХХЯ-д оролцсон хэд хэдэн эмэгтэй хэлэхдээ ганц бие эмэгтэй хүний бэлчээр, хадлан ашиглах эрхийг тэр бүр хүндэлдэггүй гэсэн нь Монгол улсын жендерийн тэгш эрхийн тухай хийсэн судалгааны үр дүн болох мал маллах нь эр хүний ажил гэж үздэг учир мал маллахыг хүссэн ч өрх толгойлсон эмэгтэйчүүдэд хүндрэлтэй байдаг гэсэнтэй адил гарч байгаа юм. Хэрэв тэд бэлчээрийн маргаанд оролцоход хүрвэл тэднийг ойшоож үздэггүй байна.

2016 оны ажлын үеэр ярилцсан ихэнх өрх толгойлсон эмэгтэйчүүд газар авахад хүндрэлтэй байдгаас гадна мал маллах ажил хэцүү, ачаалал ихтэй учир ганцаараа хийж чадахгүй байсан учир малаа худалдсан, зарим нь санхүүгийн бэрхшээл, цаг хугацааны шаардлагаар фермээ худалдсан гэжээ.

ЗБУ, ХХЯ-ын оролцогчид өрхийн хэрэгцээний орон сууцны газар, тариалангийн газрын албан ёсны бүртгэл, гэрчилгээ авах процесс жендерийн хувьд ялгавартай байдаггүйтэй харьцуулахад бэлчээр, зуншилгааны газар олж авахад эмэгтэйчүүдийг жинхэнэ ялгаварладаг гэсэн дүгнэлтэд хүрч байна. Бэлчээр, зуншилгааны газрын албан ёсны бичиг баримт гэж байдаггүй. Харин бэлчээр, зуншилгаа, хадлангийн талбай нь эрт дээр үеэс эрэгтэй хүмүүс хийж ирсэн эдэлбэрийн зохицуулалтын практик хэвээр байгаа юм.

Дээрх бүх хүчин зүйлээс шалтгаалан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдэд мал маллахад хэцүү болдог байна. 2016 оны ажлын үеэр харахад тэд ахтай эсхүл өөр эрэгтэй хүнтэй хамаатантай ойролцоо амьдарч байгаа бол мал малладаг байна. Энэ нь бидний ажиглалтыг баталж, мөн Монгол оронд хийгдсэн өөр судалгааны зарим малчин өрхүүд охидуудаа сумын төв дээр сургуульд явуулж гэртээ хүүгээ үлдээж малчин болгодог гэсэн үр дүнтэй нийцэж байна. Энэ нь дээр дурьдсан боловсролд жендерийн ялгаа их гарч улмаар эрэгтэй малчид эхнэр олоход хэцүү болж байгаатай холбож үзэж болно.

Эдгээр чиг хандлагуудаас шалтгаалан нийгэмд ямар үр дүн гарах нь тодорхой болоогүй байгаа ч жендерийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх, нөхцөл байдлыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авахдаа мал маллах ажлаа үргэлжлүүлэх сонирхолтой эмэгтэй малчин, өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн бэлчээрийн газрын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Дүгнэлт

Бид Борнуур суманд 2016 онд хийсэн судалгааны ажлын хүрээнд газар, байгалийн нөөцийн талаар олон зөрчил байгааг олж илрүүлсэн. Социализмаас хойш газар ашиглалтын олон төрлийн зөрчил ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Эдгээр зөрчил нь суманд янз бүрийн өөрчлөлт болсонтой холбоотой. Борнуур суманд шилжин ирэгсэд ихэссэний улмаас газрын хомсдол, газрын төвлөрөл, суурьшлын бус газрын наймаа, байгаль орчин талхагдах зэргээр газрын дарамт улам ихэссэн.

Эдгээр дарамтаас гадна Борнуур суманд гарч байгаа нийгэм-эдийн засаг, байгаль орчны хурдацтай өөрчлөлтүүд нь ядуу болон эмзэг бүлгийн хүмүүст илүү сөрөг нөлөө үзүүлж, томоохон үүрэг гүйцэтгэж байна. Энэхүү эмзэг бүлэг гэдэгт өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрх, залуучууд болон ажилгүйчүүд багтаж байна. Учир нь тэд орон нутгийн газрын менежментэд оролцох, газар олж авахад хамгийн их бэрхшээл тулгардаг.

1990 оноос хойш хөгжсөн уул уурхай, тухайлбал гар аргаар алт олборлох болсон нь сумын иргэдэд шинэ боломж авчирсан ч эрүүл мэнд, архидалт гээд шинэ шинэ асуудлыг бий болгож, хууль бус байсаар байгаа нь үүнийг улам бүр хурцдуулж байна. Орон нутгийн иргэд болон томоохон уурхайн компаниудын хоорондын харилцаа холбоо маш муу байсан, суманд үйл ажиллагаа явуулж буй компаниудын талаар нутгийн иргэдэд тэр бүр мэдээлдэггүй байсан бололтой. Мөн үл уурхайн үйл ажиллагаа, өргөжин тэлж буй жуулчны салбар сумын усны чанар, хүртээмжид муугаар нөлөөлсөн учир малчид онцгойлон санаа зовниж байлаа. Зарим малчид сүүлийн хэдэн арван жилд суурьшлын байр байшинтай болж, хагас эрчимжсэн болон эрчимжсэн мал аж ахуй, тариалан эрхлэх болсон зэргээр амьдрал сайжирсан гэж үзэж байгаа ч уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаас хамаардаг ихэнх хүмүүсийн хувьд амьдрал нилэнхүйдээ хэцүү болсон гэж үзэж байна. Янз бүрийн төрлийн газрыг хувьчлах явдал ихэссэнээр сумын бэлчээрийн газрыг хүртэл хашаалахад хүргэж өнө эртний уламжлалтай хамтын эзэмшлийн хэв шинжийг алдагдуулахад хүргэж, үлдсэн бэлчээрийн газар хүн, малын тоо нэмэгдсэний улмаас ихээр талхагдаж байна.

Дээрх бүх өөрчлөлтүүд, хотжих хэв маяг зэрэг нь залуу хүмүүсийг мал маллах сонирхолгүй болгож нийслэл хот руу очиж ажил хайх, ахмад хүмүүсийг хөдөө үлдэхэд хүргэж байна.

Гадны болон дотоодын хүчин зүйлсийн аль аль нь малчдын амьжиргааг маш ихээр эрсдэлд оруулж байна. Нэг талаас төрийн бодлого бэлчээрийн мал аж ахуйн амьдралын хэв маягыг дэмжихгүй байгаа юм шиг, харин оронд нь эрчимжсэн мал аж ахуй болон тариалангийн салбарыг дэмжиж уул уурхай, аялал жуулчлал, фермийн аж ахуйн хөрөнгө оруулалтад зориулж том хэмжээний газрыг олгосон мэт харагдаж байна. Нөгөө талаас ихэнхийг нь гадны санаачилгаар хийж буй хөрөнгө оруулалтууд сумын бэлчээр, ус, ойн нөөцийн чанар, хэмжээнд сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байсан.

Сайн ажилтай малчин өрхийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил үүргийн хуваарь нэг нэгнээ нөхдөг, эмэгтэй хүмүүс шийдвэр гаргах болон санхүүгийн асуудалд чухал эрх мэдэлтэй байдаг бололтой ч бид бэлэвсэрсэн эмэгтэйчүүд ядууралд өртөх эрсдэлтэй, эдэлбэрийн баталгаагүй байдалтай болж байгаа зэрэг хэд хэдэн жишээг мэдэж авсан. Хэдийгээр салалт түгээмэл биш ч өрхийн тэргүүн болох нөхрийн нэр дээр газрын гэрчилгээ гаргуулдаг явдал нь асуудал дагуулах магадлалтай. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь албан ёсны газар олгох үйл явцад ямар нэгэн жендерийн ялгаварлал байдаггүй гэдэгтэй санал нийлсэн ба зөвхөн чинээлэг ядуугаар нь ялгадаг гэж үзэж байна. Мөн олон эмэгтэй орон сууцны газар (бас нэлээдгүй хэд нь жижиг хэмжээний хүнсний ногооны газартай) өмчилдөг хэмээн мэдэгдсэн. Гэхдээ бэлчээрийн газар олж авахад уламжлалын дагуу эрэгтэйчүүд хоорондоо харилцан тохиролцдог учир өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдэд бэлчээр, зуншилгааны газар, хадлангийн газар олж авахад бэрхшээлтэй байдаг ба бусадтай маргах тохиолдолд тэд ихэвчлэн алддаг байна. Мөн бэлэвсэн эмэгтэйчүүдийн эдгээр газрын эрхийг хүндэтгэдэггүй байна. Мал маллах ажил эрэгтэй тэргүүнтэй өрхийн хийх ажил гэсэн уламжлалт нийгмийн ёс жаяг тогтсон байдаг, түүнчлэн өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд мал муулах, машин техник ажиллуулах зэрэг “эр хүний” ажлыг хийхийг хүсэхгүй мөн/эсхүл энэ хүнд ачааг даадаггүй байна.

Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхөд тохиолдож байгаа эдгээр бүх бэрхшээл нь уул уурхайгаас шалтгаалсан эрэгтэйчүүдийн өвчлөл, эндэгдэл өндөр байгаагаас шалтгаалан, мөн ерөнхийдөө газрын хомсдол, төвлөрөл, талхагдал үүсээд байгаа нөхцөлд улам бүр хурцдаж байна. Иймд бидний судалгаанаас гарсан мал маллах болон тариалангийн газрын аль альныг олж авахад бэрхшээлтэй байдаг, уул уурхайн аюул, жендерийн уламжлалт үүргийн талаарх нийгмийн хэв ёс давамгайлсан байгаа гэсэн үр дүнгээс харахад Борнуур сумын өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдэд ямар зөв сонголт байна вэ гэсэн асуулт урган гарч байна.

Жижиг бизнес эрхлэх ба албан ёсны ажил эрхлэх нь амьжиргааны чухал зүйл хэдий ч бүх хүн тийм байх боломжгүй сумын хэмжээнд албан ажил эрхлэх нь хязгаарлагдмал байдаг гэж бидэнд олон удаа хэлсэн. Харин үүний оронд ерөнхийдөө газар болон байгалийн нөөцийн талаар шийдвэр гаргахад Борнуурын бүх иргэд илүү оролцож, ялангуяа бэлчээрийн газрын талаар ядуу хүмүүс тэр дотроо эмэгтэй малчид, бэлэвсэн эмэгтэйчүүд, өвчтэй бас ахимаг насны ядуу хүмүүсийг оролцуулах хэрэгтэй байгаа гэдэг нь тодорхой байна. Ингэснээр эдгээр эмзэг бүлгийн хүмүүс урт хугацааны ужиг ядууралд орох, эдэлбэрийн баталгаа нь алдагдахаас хамгаална.

